



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2016.11.30, ЛИХАГВА ~ №248 (526)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат баасан гарагт нийгмийн халамжийн талаар мэдээлэл хийнэ. **Засгийн газар "Ухаалаг засаг"** төслийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгууллаа. **Монгол, Оросын комиссын** хуралдаанаар Эдийн засгийн коридорыг хэлэлцэв. **ЭЗБХ төмөр замын тулгамдсан** асуудлыг хэлэлцэж, 36 тэрбумын өр үүсэнийг онцоллоо. **Бэлчээрийн тухай хуулийн** төслийг дөрвөн парламент дамжуулан хэлэлцсэн ч батлаагүй байна. **АТГ 216 иргэний хувийн ашиг** сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, зөрчилгүй гэж үзжээ.

ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 2465.30 төгрөгийн ханшаар 24.2 сая ам.доллар нийлүүлээ. **Монголын хөрөнгийн** биржийн индекс 0.28 хувиар өсөв. **БНХАУ-ын коксжих нүүрс** олборлогч 112 уурхайн 94 хувь нь ашигтай ажиллажээ. **Японы өрхийн зарлага** найм дахь сардаа дараалан буурч байна.

НИЙГЭМ

НЗД-ын мөрийн хөтөлбөрт бүх дүүрэгт цэцэрлэгт хүрээлэн байгуулах талаар тусгажээ. **19 аймгийн 21 сумын** эмнэлэгт түргэн тусламжийн машин олгов. **НБОГ-аас дүгнэлт гаргуулсан** ААН-тэй хийх ус ашиглах гэрээг ирэх сарын 25-нд шинэчилнэ. **Эрчим хүчний зохицуулах** хорооны даргаар УИХ-ын гишүүн асан А.Тлейханог томилгов. **ИНЕГ-аас дрон буюу зайнаас** удирддаг агаарын хөлгийг бүртгэж эхэллээ.

ДЭЛХИЙ

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч парламентаар шийдвэл огцроход бэлэн гэсэн байна. **Шатрын ДАШТ-д 12 өргийн** дараа Норвегийн Карлсен, Оросын Карякин нар тэнцлээ. **Дэлхийн хамгийн өндөр** настан Эмма Морано өчигдөр 117 насны ойгоо тэмдэглэв. **Бразилийн хөлбөмбөгийн** "Шапекоэнсе" багийн 81 хүнтэй онгоц Колумбид сүйрчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2016.11.30



-12° | -17°

ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЖИЙГ ХЭДЭГЭЛЛИЙГ 7 ДУГААР НУУРГУУЖ ҮНШИНЭ ҮҮ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Доллар даллах найдвар



Богино хугацаанд хөрөнгө оруулалт татаж, уул уурхайн баялгийн нөөцөө нэмэгдүүлэх боломж нь хайгуулын салбар. Гэвч Засгийн газар доллар дуудах "хөзрөө" өнөөг хүртэл дэлгэсэнгүй. ►11

Б.Ганбаяр / ЗГМӨ

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Мөнгө босгох зовлон биш

Краудфандингийн зах зээлд 70 гаруй тэрбум ам.доллар эргэлдэж байна

Р.Оюунцэцэг
@oyuntsetsegZGM

"Старт ап Монголиа"-ийн залуус хоёр жилийн өмнө Дэлхийн банктэй хамтраад Greennation төслийг 500 хүрэхгүй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн нь өдгөө дөрвөн тэрбум төгрөгөөр хэмжигдэх хүртлээ тэлж, хамгийн бага зардалтай ч үр ашиг өндөртэй төсөл хэмээн олон улсад үнэлэгдэх болжээ. Үр дүнд нь гэр хорооллын 5000 гаруй яндан жагсаалаас гараад

буй. Гаднын хөрөнгө оруулалт татарч, улс орон шалдаа бууж буй өнөөгийн хүнд цаг үед эдийн засгийг алсдаа чирэх зүтгүүр нь чухам энэ юм.

Үүнээс дутахааргүй шинэлэг хийгээд ирээдүйд хэдэн тэрбум ам.доллараар үнэлэгдэх төсөл манай чадварлаг залуусын тархинд боловсорсоор буй. Жилд зуу зуугаараа мэндэлдэг ийм хэмжээний төслүүд санхүүжилт гэх том бул хар чулуунд тээглээд, дийлэнх нь цаасан дээр мөрөөдөл төдий тэмдэглэгдэн үлддэг нь харамсалтай. Яагаад ирээдүйтэй ийм төслүүдэд хөрөнгө оруулдаггүй юм бэ гэж үү? Гэдний тархинд боловсорч, цаасан дээр зурагдсан төслүүд "Барьцаа" болж чаддаггүйгээс банк зээл олгодоггүй хэрэг.

►3

ЭДИЙН ЗАСАГ

Зах зээлийн арилжаа зохиомол үнэ үүсгэхгүй

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

"Төгрөгийн ханшийн огцом уналтаас шалтгаалан бизнес эрхлэгчид, ялангуяа валютын зээлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүгийн зардал огцом өсөж, валютын ханшны эрсдэлийг удирдах боломжгүй болсноос сөхрөхөд хүрч байна" хэмээн Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /МУХАУТ/-аас гаргасан мэдэгдэлд дурджээ. Хувийн хэвшлийн дуу хоолой болж ирсэн тус байгууллага валютын ханшийг тогтворжуулах зорилгоор

Монголбанк бодлогын хүүгээ 4.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 15 хувьд хүргэсэн нь үр дүн авчирсангүй хэмээн үзэж байна.

Монголбанкны зарласан ханшаар ам.доллар мягмар гарагт 2462 төгрөгтэй тэнцлээ. Валютын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулахаар төв банк энэ өдөр 2465 төгрөгийн ханшаар 24.2 сая ам.доллар нийлүүлэв. Монголбанк энэ сард найман удаа валютын дуудлага худалдаанд оролцож, хоёр удаа татгалзсан байна. Энэ хугацаанд нийт 224.1 сая ам.доллар зах зээлд нийлүүлжээ.

►12

sales@moncon.mn
Мандала хотхон
www.mandala.mn

MONCON
MONGOLIAN CONSTRUCTION GROUP

MANDALA town

1М.КВ-ИЙН ҮНЭ
2.200.000₮.-с

12
CAP-д

Эхний ээлжийн барилга ашиглалтанд орно

Мандах амьдралын Үгээжлэл "Мандала" хотхоноос

Orchlon School
International School of Ulaanbaatar

Үндэсний ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

9401-7711
9402-7711
9403-7711

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1186.30 0.6%	785.24 0.28%	5881 0.03%	87.640 0.06%	95.930 0.09%	2465.57	357.76	37.97

Нийтлэлчийн булан


Мөнгө босгох зовлон биш

Харилцаа холбоо 10 хувиар өсөх бүрт хөгжиж буй орны ДНБ хоёр хувиар өсдөг

Монголын санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг арилжааны банк эзэлдэг тул үндсэндээ зээл хүсээд хандах өөр байгууллага өнөөдөртөө алга. Үлдсэн бага хувийг эзлэх банк бус санхүүгийн байгууллага мөн л барьцаагүйгээр их хэмжээний зээл олгоно гэвэл гонжийн жоо. Үсрээд л нүүр тахалдаг хэдэн бизнесмэнүүдийн үүдийг сахина. Тэгээд амжилт эс олбол тэр төсөл яйран болоод бөхнө. Товчхондоо, залуус хэчнэн гоё санаа сэдээд, технологийн ямар ч гоё шийдэл бүтээлээ ч түүнийгээ хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг олох нь тэмээн дээрээс будаа шүүрдэхтэй л адил зүйл ажээ.

Ийм л учраас шинэ эдийн засаг буюу краудфандинг (crowdfunding) улс эх оронд маань ус агаар мэт хэрэгтэй байгаа юм. Өөрөө мөнгөгүй ч олон хүнээс санхүүжилт босгох боломж шүү дээ. Олон нийтээс, тэр тусмаа зөвхөн дотоод бус, хилийн чанадаас санхүүжилт босгох эдийн засгийн энэхүү төрлийг Монголд шинэ тутам гэж хэлж болох ч хэрэгжих хөрс суурь нь хэдийнэ бэлэн болчихоод байгааг дараах тоо баримт бэлээн илтгэнэ.

Манай гараг дээр амьдарч буй долоон тэрбум 467 сая хүний 3.419 тэрбум нь интернэт ашигладаг бол 3.79 тэрбум нь ухаалаг утастай. Харин 2.307 тэрбум хүн социал ертөнцөд "амьдардаг". Монгол Улсын хувьд интернэт хэрэглэгчдийн тоо 2016 оны хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеийнхээс хоёр дахин өссөнийг Харилцаа холбооны зохицуулах хорооны тайлан мэдээллээс харж болно. Тэгвэл гар утас ашиглагчдын тоо 3.1 саяд хүрчээ. Тэдний хоёр сая нь ухаалаг утастайгаас 1.4 сая нь 3G, 4G ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү 1.4 сая иргэнд дээр дурдсанчлан хоёр тэрбум



2010 онд 89 сая ам.доллараар хэмжигдэж байсан краудфандингийн зах зээл 2015 онд 34 тэрбум ам.долларт хүртлээ огцом өсчээ. Харин 2016 оны хувьд энэ тоо дор хаяж хоёр дахин нэмэгдэх хандлагатай.

"хэрэглэгч" бүхий зах зээл нээлттэй байна гэсэн үг.

Түүнээс гадна манай улсын интернэт орчин улам сайжирч буй. Өнөөдрийн байдлаар Монгол орныг хэрсэн шилэн кабелийн урт 36,381 км болж нэмэгдсэн бөгөөд интернэтийн урсгал өнгөрсөн оны эцсээс 0.2, 2014 оны эцсээс 68 хувиар өссөн үзүүлэлт юм. Бидний өмнө асар өргөн зах зээл улам нээлттэй болж буйг эдгээр тоо харуулж байна. "Дэлхийн банкны тооцоолсноор харилцаа холбоо 10 хувиар өсөх бүрт хөгжиж буй орны ДНБ хоёр хувиар өсдөг байна. Тиймээс дэлхийн тэн хагастай та өөрсдийгөө холбовол эдийн засаг тань 10 хувиар өснө гэсэн үг юм" хэмээн Марк Закербергийн хэлсэн үг ч үүнийг нотолно.

Монголчуудын хувьд дотоод краудфандинг хийсэн туршлага арвин. Хуучны түүх сөхвөл 1991 онд Мэгжид Жанраисиг бурхныг дахин бүтээх шийдвэр гарахад Монголын ард түмэн мөнгөтэй нь мөнгөө, мөнгөгүй нь морь, малаа барьж ирсээр 20 тонн зэсийн цутгамал бүхий 26.5 м өндөр бурхныг бүтээж чадсан бол 1992-1995 онд олон нийт 25.3 сая төгрөгийг Монгол бөхийн өргөөг барихад хандив болгон цуглуулж байсан түүхтэй. Харин өдгөө энэхүү санхүүгийн төрөл олон улсад

илүү боловсонгүй болсныг нь бодитоор хэрэгжүүлж чадсан том жишээ бол "Ард" санхүүгийн нэгдлийн охин компани болох "Хөрөнгө оруулагч үндэстэн" хэвлэх үйлдвэрийн хувьчлалд оролцох санаачилгыг фэйсбүүкээр амжилттай өрнүүлсэн явдал. Үүний үр дүнд 509 хөрөнгө оруулагч нэгдэж чадсан нь чамлах үзүүлэлт биш юм. Фэйсбүүкээр хандив тусламж гуйж, сайн санаат хүмүүсийн тусламжаар хэргээ бүтээж буй тохиолдлууд ч краудфандингийн бас нэгэн жишээ болно.

» Манай гараг дээр амьдарч буй долоон тэрбум 467 сая хүний 3.419 тэрбум нь интернэт ашигладаг бол 3.79 тэрбум нь ухаалаг утастай.

» Монгол Улсын хоёр сая иргэн ухаалаг утастайгаас 1.4 сая нь 3G, 4G ашиглаж байна.

» 1992-1995 онд олон нийт 25.3 сая төгрөгийг Монгол бөхийн өргөөг барихад хандив болгон цуглуулж байсан.

Харин одоо бидэнд санаачилга, сайн менежмент, нэгдсэн платформ хэрэгтэй байна. Demjleg.com-ыг эс тооцвол манайд одоогоор нэгдсэн томоохон платформ байхгүй гэж болно. Тус цахим хуудсаар зочлоод нэг үзээрэй. "Элэг нэгт Монгол" сангийн санаачилсан Монголдоо хямд өртгөөр элэг шилжүүлэн суулгахад шаардлагатай тоног төхөөрөмж оруулж ирэх төслийн хүрээнд 73.3 сая төгрөг босгож чадсан юм. Яг одоогоор demjleg.com-ийнхон "Хүрээ амаржих газар" буюу хуучнаар II төрөхийн Нярайн тасгийг тохижуулах хумүүлэгийн төслийн санхүүжилт босгох ажил ид өрнүүлж байна. Хандив цуглуулах хугацаа ирэх сарын 10-нд дуусах бөгөөд одоогоор 10.3 сая төгрөг цуглажээ. 1959 онд ашиглалтад орсноос хойш ганц ч удаа гар хүрээгүй энэхүү төрөх эмнэлгийн Нярайн тасгийг олны хүчээр засах боломжийг краудфандинг олгож буй юм. Энэ бол эхлэл.

Инновацийн төслүүдээ энэ замаар мөнгө босгож, хэрэгжүүлбэл эдийн засагт томоохон дэмжлэг болох ирээдүй байгаа юм. Дэлхий нийтээрээ технологийн салбар руу шуурч, богино хугацаанд их хэмжээний баялаг бүтээх боломж гэдгийг нь олж харсан учраас улс орон бүр энэ төрлийн хөрөнгө оруулалтад

гол анхаарлаа хандуулж байна. Олон улсад танигдсан цахим хуудас бол Indiegogo.com, Kickstarter.com, Gofundme.com. Эдгээр цахим хуудас олон гарааны бизнесийн аврал болсон. Манай улсын хувьд зөвхөн Шинжлэх ухааны академид л гэхэд хэрэгжихэд бэлэн 19 төсөл хөрөнгө оруулагчаа "хүлээж" байна. Зөвхөн инновацийн шүү дээ. Яагаад энэ төслүүдээ зөв танилцуулаад олон улсаас хөрөнгө босгож болохгүй гэж.

2010 онд 89 сая ам.доллараар хэмжигдэж байсан краудфандингийн зах зээл 2015 онд 34 тэрбум ам.долларт хүртлээ огцом өсчээ. Харин 2016 оны хувьд энэ тоо дор хаяж хоёр дахин нэмэгдсэн хэмээн тухай Demjleg.com-ийг үүсгэн байгуулагч С.Баярсайхан ярьсан. Энэ бол зүгээр л дэлхийн өнцөг булан бүрт байгаа доноруудын хандивлаж буй мөнгөний хэмжээ. Цахим ертөнцөөр дамжин эргэлдэж буй тэр их хэмжээний мөнгөнөөс амсах төдий халбагадаа уу, ахиухан шаанагадаа уу гэдэг нь бидний овсгооны л асуудал болоод байна.

Хүн хүн царай алдаж, хоосон хаалга мөргөхийн оронд цаг хугацаа, орон зайг товчилж, олон нийтээс хөрөнгө босгох нь дэлхийн эдийн засгийн трэнд болоод байна. Олны хүч оломгүй далай гэдэг биш бил үү. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ

Монголд краудфандинг (crowdfunding) хөгжих боломж байгаа юу?

НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙ БЭЛЭН БИШ БАЙНА

-Дэлхийд краудфандинг буюу олон нийтээс санхүүжилт босгох олон хэлбэр байдаг. Харин Монгол Улсад хөгжих хараахан болоогүй байна гэж үзэж байгаа. Учир нь нийгмийн сэтгэл зүй бэлэн биш байна. Гэхдээ краудфандинг хөгжих тогтолцоог зөв хийх хэрэгтэй. Краудфандинг буюу олон нийтээс санхүүжилт босгох шинэ хэлбэр нь биржийн зах зээлтэй адил зүйл. Биржийн зах зээл нь олон нийтээс санхүүжилт босгох энэхүү шинэ хэлбэрээс илүү найдвартай. Гэвч Монгол Улсад биржийн зах зээл өөрөө төдийлэн сайн хөгжихгүй байгаа шүү дээ. Монголд краудфандинг амжилттай хийсэн ганц хоёр тохиолдол бий. Тиймээс олны танил хүн болон сайн төсөлд тулгуурлан краудфандинг хөгжүүлэх бүрэн боломж байгаа.

СЭЗИС-ийн багш Ж.Дэлгэрсайхан

МОНГОЛ УЛС КРАУДФАНДИНГ ХИЙЖ БАЙСАН АРВИН ТУРШЛАГАТАЙ

-Монгол Улс crowdfunding хийж байсан арвин туршлагатай. Тухайлбал, Бөхийн өргөө, Жанрайсаг бурханг бүтээхэд краудфандинг хийж, санхүүжилт босгосон шүү дээ. Сүүлийн жилүүдэд ч краудфандинг хийж, санхүүжилт босгосон тохиолдол олон байгаа. Цахим ертөнцөөр дамжуулан краудфандинг хийх нь олширч байна. Нөгөөтэйгүүр, Үндсэн хууль болон Иргэний хуульд краудфандинг хийх нөхцөл боломжийг нь олгосон байгаа. Өөрөөр хэлбэл, краудфандинг хийхийг хуулиар хориглоогүй учир хөгжих бүрэн боломжтой. Магадгүй краудфандинг хийхэд зах зээл болон нийгэм нь бэлтгэгдээгүй байгааг үгүйсгэхгүй. Тиймээс энэ талаар зөв ойлголтыг нийгэмд өгөх ёстой.

Эдийн засагч Д.Ангар

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Амьд ертөнц

Хүйтрэх тусам ороо нь орсон буурын зан авир илүү хурц, догшин болдог

З.Цэлмэг
@tselmegZGM

“Говийн гайхамшигт б” цувралын ээлжит амьтнаар хавтгай тэмээг танилцуулж байна.

Хоёр бөхтэй тэмээг бодвол арай намхан, нарийн урт хөлтэй, шөвгөр жижигхэн бөхтэй хавтгайг говийн хаан хэмээн “авгайлдаг”. Учир нь, хавтгай ус уухаар ирмэгцээ булаг шанд, бүрдэнд усалж буй хулан, хар сүүлтийг түрэмгийлэн хөөж, зөвхөн ганцаараа л усалдаг онцлогтой. Ингэхдээ 20-30 литр усыг 30-120 минутанд уух чадвартай аж. Харин ус ихтэй газар бол энэ хэмжээний усыг 27 минутанд л залгилж орхидог.

Гэхдээ хуурай, сэрүүн улирлын үеэр 40-60 хувийн чийгтэй ургамлаар хооллож байвал дусал ус амсахгүйгээр хагас жил ч тэсэх тэнхээтэй амьтан. Тиймдээ ч бороо орох газрыг хамгийн сайн мэддэг. Бүр борооны үүл гарахыг ч андахгүй. Ерөөс говийн хааны мэдэрхүйн эрхтнүүд бусдаасаа давуу хөгжсөн аж. Тиймээс ч сонор сэрэмжээр барагтай амьтныг урдаа гишгүүлдэггүй байна. Хурц хараа, үнэрч хамарныхаа тусламжтай салхи үнэрлэн, олон км-ийн алсаас ч хүн болоод аюулыг мэдэж, өөрийгөө хамгаалах онцгой чадвартай.

Одоогоос таван сая жилийн тэртээ буюу плиоценийн үед Америкаас тив, далайг гатлан Төв Азид ирж нутагшсан энэ сүрдэг амьтныг бид тэмээний өвөг гэдгээс өөрөөр бараг л мэдэхгүй. Аляска болон Чукотскыг холбосон нарийн хуурай замаар дамжин Ази тивд ирсэн хавтгай Зүүн Азиас Зүүн Европ, Баруун хойд Африк хүртэлх уудам нутагт тархжээ. Харин энэ амьтны нэн эртний овгийн төлөөлөгчид 54 сая жилийн тэртээ амьдарч байв. Хоёр бөхтэй тэмээнээс 11-25 сая жилийн тэртээ салбарласан



Тэнүүн говийн хаан

гэдгийг сүүлийн үеийн судалгаа нотолж буй. Тэгвэл хоёр болон нэг бөхтэй тэмээ таван сая жилийн өмнө салбарлажээ.

Азийн цөлийн бүсэд амьдарч байгаа тэмээний овгийн хамгийн сүүлчийн зэрлэг төлөөлөгч болох хавтгайн нэг сүрэгт дунджаар 5-12 хүртэлх бодгал байдаг. Харин орооны өмнөх үедээ хавтгайн цугларалт 120 хүртэл нэмэгдэх тохиолдол ч бий. Хавтгайн ороо нийлж 12-2 дугаар сард үргэлжилдэг. Хүйтрэх тусам ороо нь орсон буурын зан авир илүү хурц, догшин болдог байна. Энэ үедээ сүрэгт өөр буур дөхөх, ойртох үед маш ширүүн тэмцэл өрнүүлнэ. Тэмцэл нь нэг нэгнээ үхэлд хүргэж байж дуусдаг аж.


Харин 3-4 наснаас эхлэн үржилд орсон ингэний хээлээ тээх хугацаа 13 сар үргэлжилдэг.

Ингэ босоогоороо ботголдог бөгөөд ихэвчлэн нэг л ботго гаргадаг. Ботго төрөхдөө 32-34 кг жин татдаг ба эхээс унаснаасаа хойш 15-30 минутанд амжиж хөл дээрээ тэнцэн, хөхөө амладаг байна.

Сүрэг хэдэн хавтгайтай байх нь говийн булаг, бүрдийн тооноос шууд хамаарна. Өөрөөр хэлбэл, сүргийн тоо толгойн тогтвортой байдал, нөхөн үржих чадвар, улирлын шилжилт хөдөлгөөн, газар нутгийн тархалт нь бүхэлдээ булаг, шандын байршлаас шалтгаалдаг аж. Биологич, амьтан судлаач Я.Адьяагийн хэлснээр Алтайн цаадах говийн хавтгай хуурай бүсийн хөхтнүүдийн адилаар ганд тэсвэртэй бутлаг, сөөглөг, нэг ба олон наст бударгана зэргээр хооллодог байна. Хавтгай уудам

бэлчээрт ургамлыг сонгож түүвэрлэн, явдал дундаа иддэг онцлогтой. Ийн идээшлэх үедээ 10-12 км/ц хүртэл хурдалдаг амьтан юм. Энэ нь говийн бүс биологийн бүтээмж багатай, идэш тэжээл сийрэг байдагтай холбоотой.

Төв Азийн өндөрлөгийн эрс тэс уур амьсгалд дасан зохицох онцгой чадвар хавтгайд бий. Зуны цагт говийн агаарын температур 45 хэм давж байхад хавтгайн биений дулаан 33-40 градусаас хэтэрдэггүй. Биений дулаан нь нэмэгдэх тусам хөрс идэвхтэй ялгаруулж, дулаан нь улам нэмэгдэхээс сэргийлдэг. Тиймдээ ч хавтгайн бөөр өндөр агууламжтай шээс ялгаруулахад зохилдсон байдаг аж. Хавтгай 8-9 дүгээр сард ус бараг л уудаггүй. Усгүйгээр удаан байдаг нууц нь бөхнийхөө



өөхний тусламжтай биений усны хэрэгцээг хангадаг байдгийг тогтоожээ. Иймээс ч хавтгай биений жингийнхээ 25 хувийг алдахад ч цусанд нь агуулагдах ус биенийнх нь чийг, дулааныг зохицуулсаар байдаг.

Харин хавар болон зуны эхэн сарын хур багатай үед хавтгай хоногт нэг л удаа ус уудаг. Говийн хаан цөлийн халуунд нар болон аюулаас өөрийгөө хамгаалах газар олж, удаан нуугддаг. Өдрийн ид халуунд болон олон улсын хөхтний уулангарын сүүдэр бараадаж халууныг өнгөрөөдөг байна.

Одоо хавтгай тэмээ үндсэндээ тусгай хамгаалалттай газар нутагт л амьдардаг. 1979 онд хавтгайн эзэмшил нутаг нь 17359 ам км талбайд байсан бол 2002 онд тодорхой тооны хавтгайд сансрын дохиоллолтой хүзүүвч суулгаснаар газар нутгийн хэмжээ нь 28343 ам км байгааг тогтоосон байна. Хавтгай тэмээг Монголд 1930 оноос агнаж хориглон, Ан агнуурын тухай хуульд зааж өгсөн юм. Говийн хаан нь Монголын Улаан ном болон олон улсын хөхтний Улаан жагсаалтад орсон нэн ховор, эмзэг амьтан аж. [ЗГМ]

Сонин хачин Бяцхан тариачид

Номхон далайн Фижи арлын шоргоолж дэлхийн хамгийн бяцхан тариачин байжээ. Гэндхийн шоргоолжнууд зургаан төрлийн ургамлын үр суулгаж, арчилж тордож байсан байна.

Шоргоолж тариан талбайд хөгц зөөдөг талаарх мэдээлэл өмнө нь гарч байсан ч Мюнхенийн их сургуулийн судлаачид энэ удаа шоргоолжийг ургамал тарьдаг байсныг батлах

судалгаа хийжээ. “Philidris” хэмээх энэхүү бяцхан тариачин зургаан төрлийн ургамлын үрийг цуглуулж, модных нь ан цавтай хэсгүүдэд суулгасан байна. Мөн суулгасан үрээ тогтмол эргэж, орчин тойрныг нь цэвэрлэж байжээ. Ингэж шоргоолж, ургамал хоёр бие биетэйгээ харилцан зохицож байсан хэмээн судлаачид тэмдэглэжээ. [ЗГМ]

Канадууд зөгийгөө хамгаалж байна

Гол горхийг бохирдуулж, усанд амьдардаг шавжуудыг устгаж байгаа учраас ниеникотиноид хэмээх пестицидийн хэрэглээг хориглохоор болсноо Канадын эрүүл мэндийн бодлого зохицуулагч байгууллагаас мэдэгдэв.

Түүгээр ч үл барам тус улсын гол горхины амьтан, ургамлыг устгах аюулд оруулж болзошгүй гэж үзсэн учраас өөр хэд хэдэн төрлийн пестицидийн бүх хэрэглээг хориглох хүсэлтэйгээ тус байгууллага илэрхийлсэн байна.

Ниеникотиноид пестицидийн хэрэглээ нь дэлхий даяар зөгийний тоо толгойг устгахад нөлөөлж байгаа нь олон судал-

гаагаар тодорхой болсоор байна. Гэсэн ч зөгийний хорогдлыг бүлийн сарнилтай холбон тайлбарлахыг оролддог хэсэг бүлэг байдаг юм.

Мэргэжлийн байгууллагаас хийсэн шинжилгээгээр дээрх хоёр төрлийн пестицидийн хэрэглээ нь усны шавжнуудад хор учруулах хэмжээнд байгаа аж. Эрдэнэшиш болон канола тосны ургамал, төрөл бүрийн зүлэг, гацуур мод төдийгүй тэжээмэл амьтны бөөсийг устгахад өргөн хэрэглэдэг дээрх пестицид нь шавжны төв мэдрэлийн системийг гэмтээдэг гэсэн дүгнэлтэд судлаачид хүрсэн байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
СОНИН ХАМ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургалыг үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

Гадаад контент, соёл энтертайментын алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901682

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

846580004291124 00526

UBinfo.mn

Та доорх кодыг уншуулж Засгийн Газрын Мэдээ Financial Times сонинг нэг дороос уншина уу

Та QR code уншуулахыг тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131
info@zasag.co
UBinfo.mn

Нийгэм

ЗГМ: ТОДРУУЛГА

Хотын захиргааны шинэ цогцолбор "үлгэр" болжээ

2019 онд шинэ байрандаа орохоор байв

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Улаанбаатарын төвлөрлийг сааруулах, олон төвт хот болгон хөгжүүлэх зорилгоор хотын захиргааг Баянхошуу руу нүүлгэх шийдвэрийг нийслэлийн өмнөх удирдлагууд гаргаж сүр дуулиан болж байсан билээ.

Сонгинохайрхан дүүргийн VI хороо буюу хуучнаар Хан-нын материалын үйлдвэрийн орчмын есөн га газарт уг шинэ цогцолборыг барихаар шав тавьж, Солонгосын хөрөнгө оруулалттай "Халла" групп төсөл хэрэгжүүлэх эрх авсан.

2013 оны аравдугаар сараас эхлэн "Халла" групп барилгын зураг төслийг боловсруулан нийслэлийн удирдлагуудад танилцуулж, санал авсан юм. Түүгээр ч зогсохгүй талууд инженерийн дэд бүтэц, цахилгаан хангамж зэрэг нарийн төлөвлөлтийн ажлаа тохиролцсон байв.



ОРОН НУТАГ

» ОРХОН

"Түрээсийн орон сууц" хөтөлбөрт хамрагдсан иргэдэд аймгийн Засаг дарга батламж гардууллаа. Хөтөлбөрийн хүрээнд 34 айл орон сууцтай болж, 1-3 өрөө байрыг тав хүртэлх жилийн хугацаатай түрээсийн гэрээгээр эзэмших юм. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хоёр тэрбум төгрөгөөр Дэнж багт байрлах "Баян-Өндөр" хороололд 40 айлын орон сууц худалдан авчээ. Үүний 34-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмад настан, өрх толгойлсон эцэг, эх, хувийн хэвшилд ажиллаж буй иргэдийн төлөөлөлд өгсөн байна.

» БУЛГАН

Булган аймаг энэ өвөл 18 тонн мах нөөцөллөө. Махны 12340 кг нь үхэр, 5710 кг нь хониных байна. Өнгөрсөн онд "Баян даш хайрхан" ХХК үхэр, хонины 17 тонн мах нөөцөд бэлтгэн нийлүүлсэн бол энэ онд тус компани дахин сонгон шалгаруулалтад тэнцжээ. Хонины мах нь яс их, мах багатай учраас иргэдээс үхрийн мах түлхүү нөөцлүүлэх санал ирсэн байна. Ноднин үхрийн мах 5500, хонины мах 5700 төгрөгөөр борлуулж байв. Махны чанар, хадгалалтын горимд Булган аймгийн мал эмнэлгийн лаборатори хяналт тавьж ажиллана.

ГОВЬ-АЛТАЙ

Аймгийн төвд мах боловсруулах үйлдвэр нээгджээ. Энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор орон нутагт 50 орчим ажлын байр шинээр бий болж, аймгийн төсөвт тодорхой хувь нэмэр оруулах аж. Мах боловсруулах үйлдвэр нь хоногт 100 бод, 1000 орчим бог нядлах ба гүн хөлдөөх зоорь нь 400 тоннын хүчин чадалтай юм байна. Мөн үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд иргэдийг баталгаатай хүнсээр хангах боломж бүрдэх ажээ. Тус аймаг мах боловсруулах үйлдвэргүй байсан цөөн аймгийн нэг юм.



39400 ХАРИЛЦАГЧ НЭГДЭЭД БАЙНА

www.HURIMTLAL.com
хаягаар дансаа нээлгээрэй

"Халла" группын архитекторын танилцуулснаар уг цогцолборын барилгыг 50400 ам метр талбайд барихаар төлөвлөсөн юм. Цогцолборын ерөнхий загвар нь хүний нүд мэт хэлбэртэй байхаар төсөөлж боловсруулсан ба 2015 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байв.

Тухайн үеийн нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга Ё.Гэрэлчулуун цогцолбор барихад нийт 37,1 тэрбум төгрөг шаардлагатайг онцолж байсан.

Дөрвөн жилийн өмнө барилгын шавыг тавьж, багагүй ажил хийж

гүйцэтгээд байв. Тухайлбал, 9,2 га талбайг бүрэн чөлөөлж, барилгын дизайн, төлөвлөлт, зураг төсөл, ажлын инженер геологийн судалгааны дүгнэлтэд магадлал хийж амжжээ. Гэвч эдийн засгийн хямралаас шалтгаалан төсөл хэрэгжүүлэгч "Халла Гонсол" ХХК гэрээ байгуулах, барилга угсралтын ажил эхлүүлэх боломжгүйгээ илэрхийлснээр төслийн ажил зогсонги байдалд оров.

Гэтэл энэхүү төслийг Унгарын хөрөнгө оруулалттай "Глобал бридж консерциум" компани

концессын гэрээгээр гүйцэтгэхээр болж, барилгын ажлаа эхлүүлсэн. Тэд барилгын ажлыг гадна тохижилтын хамт өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж, нийслэлийн шинэ цогцолбор бүрэн ашиглалтад орсны дараа гурван жилийн хугацаанд төлбөрөө авахаар болсон юм. Төслийн явцад 800-1000 иргэн ажлын байртай болж, 150 орчим тэрбум төгрөгийг гүйцэтгэгч компаниудад олгохоор төлөвлөсөн байлаа. Ийнхүү 2019 онд хотын захиргаа шинэ байрандаа үйл ажиллагаагаа явуулах боломжтой болох байсан.

Гэтэл нийслэлийн Засаг дарга хотын захиргааг нүүлгэхгүй гэдгээ нийслэлийн ИТХ-ын үеэр мэдэгдлээ. Үүнийг тодруулахаар нийслэлийн ЗДТГ-ын дарга М.Отгонбаяртай холбогдсон юм. Тэрбээр "Концессын гэрээгээр 220 тэрбум төгрөгөөр барих гэрээ байгуулсан байсан. Гэвч ийм хэмжээний санхүүгийн боломж байхгүй. Өнгөрсөн наймдугаар сард Засгийн газраас концессын гэрээг зогсоох үүрэг өгсөн. Тиймээс хотын захиргааны шинэ цогцолборыг барихгүй байхаар шийдвэрлэлээ" гэв. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД

ДОХ-ын 218 тохиолдол бүртгэгджээ

Х.Ананд
ЗГМ

Монгол Улсад ДОХ-ын 218 тохиолдол бүртгэгдээд байна. Гэхдээ бүртгэлтэй хоёр өвчтөний ард гурван оношлогоогүй хүн байдаг гэж тооцвол энэ тоо 457 болохыг ХӨСҮТ-өөс мэдээллээ. Эдгээр иргэний хувьд 15-49 насныхан байгаа ба нийт тохиолдлын 80 хувь нь эрэгтэйчүүд аж. Одоогоор халдварын улмаас 35 хүн нас барсан байна.

2014 онд хийсэн судалгаагаар ижил хүйстний дунд тархалт 12 хувьтай гарчээ. ДЭМБ-ын мэдээлснээр ДОХ-ын халдварыг 20 насанд нь оношилж, эмчилгээнд хамруулвал 71 наслах боломжтой гэдгийг баталжээ.

Эс бөгөөс 42 наслах тооцооллыг гаргасан байна.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн хэлтсийн дарга Ж.Энхзул "Халдварласан хүнийг эрт илрүүлж, эмчилгээнд хамруулах нь чухал. Гэвч монголчуудын хувьд эмнэлгээр үйлчлүүлэх соёл хэвшээгүй, ямар нэгэн сэжигтэй тохиолдолд өөрт мэдрэгдсэн ч оношлуулдаггүйгээс ДОХ-ын эрт илрүүлэлт хангалтгүй байна" гэлээ.

Халдвараас сэргийлэхэд бэлгэвчийг тогтмол хэрэглэх нь 85 хувь хамгаалдаг. Эрүүл мэнддээ анхаарч, зовиур илрэхгүй байсан ч жил бүр шинжилгээнд хамрагдаж хэвших нь эрсдлээс өөрийгөө хамгаалах хамгийн том боломж гэдгийг эмч нар онцлолоо. [ЗГМ]

Аймаг, сумдын эмнэлэгт түргэний машин өглөө

Орон нутагт өвөлжилт хүндэрч байгаагай холбогдуулан аймгуудын нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд улсын нөөцөөс шуурхай албаны түргэн тусламжийн автомашин олголоо. Нийт 19 аймгийн 21 сумын эрүүл мэндийн төвд УАЗ-22069 маркийн фургон

автомашин, УАЗ-31519 хантер маркийн автомашин өгчээ. Улсын нөөцөөс олгож буй шуурхай албаны түргэн тусламжийн автомашин нийт 630 гаруй сая төгрөгийн өртөгтэй.

ОБЕГ-ын дарга Т.Бадрал "Өвөлжилтийн нөхцөл байдал ихэнх нутгаар хүндэрч байгаагай

холбогдуулан Улсын онцгой комиссоос тодорхой арга хэмжээ авч, шийдвэр гарган ажиллаж байна. Манай оронд 2009-2010 оныг дамнан зудын гамшиг нүүрлэж, 565 тэрбум төгрөгийн буюу улсын эдийн засагт маш том хохирол учруулж байсан. 2016-2017 оны өвөлжилт,

хаваржилтын хувьд ч нөхцөл байдал улсын хэмжээнд хүндрэх төлөвтэй байна" гэв.

Дашрамд дурдахад, ирэх оны нэг, хоёрдугаар сард эрс хүйтрэх, цас их орох, улмаар өвөлжилт хүндэрч болзошгүй байгааг цаг уурын байгууллагаас анхааруулсан байна. [ЗГМ]

MADE IN MONGOLIA

#МОНГОЛДУЙЛДВЭРЛЭВ

Лхагва гараг /давталт/

11:00

11:00 Баасан гараг /давталт/

20:00 Мягмар, Пүрэв гараг /давталт/



Ирээдүйн Монгол иргэдийг бүтээх салбарт 2014 оноос эхлэн ажиллаж буй Эко гэр цэцэрлэг Олон улсын шилдэг стандартыг Монгол хүүхдэд зориулсан судалгаа, сургалттай хэрхэн хослуулж байгаа талаар энэ удаагийн дугаарт танилцуулна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 400 гаруй хувийн цэцэрлэгээс сургалтын орчин, хөтөлбөр, чанараараа хэрхэн ялгарч байгаа талаар мөн боловсролын салбарт хийхээр төлөвлөж буй шинэчлэлийн нь тухай Эко гэр цэцэрлэгийг үүсгэн байгуулагчтай ярилцлаа.

ШИНЭ ЖИЛ

КИНО

Ирэх сард үзэх
10 кино

Зул сар баяр хөөрөөр дүүрэн ч амиа хорлолт хамгийн их нэмэгддэг нь сүүдэрт тал билээ

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Таныг “Үзэх юмсан” гэж бодож дуусаагүй байтал *Love actually*, *The Holiday*, *Home Alone*, *The New Year's eve* тэргүүтэй шинэ жил, зул сарын баярт зориулсан кинонууд суваг болгоноор гарах болно. Гэхдээ та Барууны хэвцсэн ойлголтоос өөр өнцөг харахыг хүсвэл дараах 10 киног заавал үзээрэй.

MIRACLE ON THE 34TH STREET-1994

Хуульч эр бяцхан охины хамтаар өөрийгөө Санта Клаус гэх эрийн үнэн мөнийг батлах хэрэгтэй болно. Ид шидэд итгэхээ байсан насанд хүрэгчдийн бодлыг өөрчлөхийн тулд тэд эхлээд өөрсдийн эргэлзээтэй нүүр тулна.

DIE HARD-1988

Нью-Йорк хотын цагдаагийн газрын офицер Жон Маклейний гэргийг хэд хэдэн хүний хамтаар герман террористууд Зул сарын баярын үеэр барьцаалснаар тэмцэл эхэлнэ. Тус кино 1990-ээд онд тулаант киноны салбарт тэсрэлт болж чадсан бөгөөд одоо ч хүмүүсийн сэтгэлд хоногшсон хэвээр.

JUST FRIENDS-2005

Зул сарын баярын үеэр төрөлх хот руугаа зүглэсэн залуу ахлах сургуулийн анхны хайртайгаа

дахин учирдаг. Тухайн үед илүүдэл жинтэй, элэг доог болсон азгүй нэгэн байсан ч одоо халуухан дуучин бүсгүйтэй болдог, сайхан залуу болжээ. Түүний анхны хайрын түүх ч бүтэлгүй. Охин түүний найзын хайраар л хайрладаг. Энэ бүх эдэрээтэй дурсамжууд төрж өссөн хотод нь ирээд сэдэрх болов уу.

YOU'VE GOT MAIL-1998

Нэгэн бүсгүйд нэг залуугаас цахим шуудан ирнэ. Сонниучан зандаа хөтлөгдөж хариу бичсэнээр тэдний харилцаа гүнзгийрдэг. Тэдний хэн хэн нь жинхэнэ хайр дурлалтайгаа учирсан гэдэгтээ итгэлтэй байсан ч нүүр тулах мөчид бүх зүйл орвогцоор эргэхийг мэджээ. Учир нь тэд амьдрал дээр бие биенээ үгүйсгэж, үзэн яддаг бизнесийн өрсөлдөгчид билээ. Хайрын бэлгэдэл болох Зул сарын баяраар тэд ямар сонголт хийх бол. Заавал үзээрэй.

NOVEMBER CHRISTMAS-2010

Хатан зоригт бяцхан охин хорт хавдартай тэмцэж буйг харуулсан кино. Аймшигт өвчин түүний дотнын хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ.

CHRISTMAS WITH HOLLY-2012

Хайрт эхийгээ алдсан зургаан настай охин сэтгэл санааны гүн цочролд орж, огт ярихаа больдог. Түүнийг гурван авга нь асран халамжлах болсноор гэр бүлийн үнэ цэнэ, хайр халамж хэр чухал болохыг ухаарах ажээ.

A CHRISTMAS CAROL-2009

Чарльз Диккенсийн алдарт зохиолоор эсдэвлэсэн хүүхэл-

дэйн кино. Викториягийн үед амьдарч байсан нэгэн харамч, хүйтэн сэтгэлтэй өвгөн ид шидийн гэмээр аялалд гарна. Зул сарын сүнснүүд түүнтэй уулзаж, болох болохгүйг нь харуулахад тэрбээр нүглээ наминчилж, замаа засахад хүрчээ. Зул сар бол бүсдүг хайрлаж, хайрлуулах, гэм нүглээ ухаарч, гэмших баяр. Ингэж чадвал сайн сайханд хүрч болохыг дээрх киноноос үзээрэй.

THE FAMILY STONE-2005

Сахилга баттай, хуучинсаг үзэлтэй бизнес эрхлэгч эмэгтэй найз залуугийнхаа гэрт баяраар зочилно. Гэвч гэр бүлийнхнийх нь нээлттэй, этгээд байдал түүний оршихуйгаас дэндүү өөр. Бүсгүй яг л уснаасаа гарсан загас мэт боловч хайртай залуугийнхаа төлөө хорвоогийн олон өнгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болно.

IT'S A WONDERFUL LIFE-1946

Сэтгэлээр унаж, урам хугарсан бизнесмэн наашлах, цаашлахын зааг дээр байх тэр мөчид тэнгэрийн элч аврал хайрлахаар иржээ. Өөрийн бүтэлгүй нэгэн гэж бодсон түүнгүйгээр амьдрал ямар байхыг тэнгэрийн элч үзүүлснээр үйл явдал эргэнэ.

STERMOM-1998

Эдгэршгүй өвчин туссан эмэгтэй салсан нөхрийнхөө шинэ эхнэртэй учраа олох хэрэг гарна. Өөрөө хорвоог орхиоос өөр замгүй тул ирээдүйд хоёр хүүхдийнх нь ээж болох Жулиа Робертсын бэлдэх хэрэгтэй. Гэвч Жулиа Робертс ээж болохыг, хүүхдүүд ч шинэ ээжтэй болохыг хүсэхгүй. Гэхдээ эдэрэг асуудалтай нүүр тулж байж л шийднэ шүү дээ. [ЗГМ]

ЗАГВАР



Хамбан даашинз эргэн ирлээ

Ам.долларын ханш чангарсан энэ үед охид, бүсгүйчүүд бартерийг сонирхох болжээ. Тэд ганц, хоёр өмсөөд л өлгөнчхөн даашинзуудаа холио, солионы өдөрлөгүүдээр солилцох гэж байна. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн өдөрлөг манайд олон зохиох болсон. Хүүхдийн эдлэл хэрэгсэл, хувцас, даашинз, гэр ахуйн бараа гээд л сонголт арвин. Сонирхуулахад, ирэх сарын 11-нд шинэ жилийн даашинз, гутал, гоёл чимэглэл солилцох өдөрлөг “Gandan Live House”-г болох ажээ.

Гэвч сонголт үргэлж таны гарт байх болно. Хэрэв та хүний хувцас өмсөх дургүй бол наашаа анхаараарай. 2016 оны өвлийн онцлох зүйл бол хамба хилэн даашинз. Мөн онгорхой,



ШИНЭ САНАА

Шинэ жилээ шинэлэг хийе

Жижиг, дунд бизнес эрхлэгчид ажилтнуудаа идэвхтэй хамруулж, нүсэр үйл ажиллагаатай шинэ жил зохион байгуулах боломжоор хомс байдаг. Тэр дундаа эдийн засаг хямралтай байгаа энэ үед байгууллага хамт олон шинэ жилээ хэмнэлттэй, өвөрмөц байдлаар тэмдэглэх болжээ. Ихэнх албан байгууллага үйлчилгээ эрхлэгчидтэй бартер хийх маягаар баяраа тэмдэглэж байна.

Тухайлбал, нэгэн компани

шинэ жил тэмдэглэх гэж олон саяын зарлага гаргадаггүй. Харин үүний оронд ажилтнуудыгаа гэр бүлээрээ баяраа сайхан тэмдэглээрэй өгдөг 100-200 мянган төгрөг өгдөг аж. Гэхдээ шинэ жилийн баяр хүн бүрийн сэтгэлийг догдуулдаг учир ажилтнууд нь цалингаасаа төсөв гарган тэмдэглэж байна. Харин “Brand Media Group”-ийн хамт олон шинэ жилийн баяраа “Яг хэн шиг” гэсэн сэдвээр тэмдэглэж байна. Brand Media Group”-ийн захирал



чимэглэлтэй, саатай материалтай ч дээрх хэв загварын даашинз сонгоорой.

Америкаас брэндийн хувцас захиалж өгдөг “Shopaholic guide” сайтын эрхлэгч С.Энхжин “Шинэлэг зүйл гэвэл албан байгууллагууд шинэ жилийн баяраа тэмдэглэхдээ тусгай хувцаслалт заадаг болсон байна. Энэ жил яг тодорхой



трэнд гэхээр зүйл байхгүй. Хүмүүсийн хандлага, эрэлтээс үндэслэвэл дараа нь өөр зүйлд өмсөх боломжтой даашинз их эрэлттэй болжээ. Урт даашинз нэг их сонирхохгүй байгааг анзаарсан. Илүү уламжлалт загварт дуртай хүмүүс А хэлбэртэй тотно тэргүүтэй сонголт түлхүү хийдэг. Гэхдээ дэлхийн загварын трэндийг дагалд тор, тор бас дахин тор нэмэх нь торго гэсэн замналаар явна. Түүнчлэн жампсют, ромпер, унтлагын хувцас мэт нимгэн, торгон материалтай энгэр нь зөрсөн даашинз моодонд орсон” гэв. [ЗГМ]

UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

- 1 Хүүхдийн автомашины суудал зарна. Утас: 99195446 , 99165779
- 2 Машины халдаг суудал (өвлийн) зарна. Утас: 89130673
- 3 Хүүхдийн автомашины суудал шинээр ирлээ. 120-140 мянган төгрөгийн хооронд байгаа. Утас: 99195446
- 4 Машины тоос сорогч зарна. Утас:99309609
- 5 2009 оны "FX35" хямд зарна. Үнэ: 25 сая Утас: 99111468
- 6 "G500" загна 2004-2012. Дотор гаднагүй он залуу болгосон машин оролцуулна. Утас: 99993434
- 7 2003 оны 2012 орж ирсэн сувдан цагаан өнгөтэй, beams-2.0 мотортой, ухрах камертай "Grand mark 2" яаралтай зарна. Үнэ 5 сая. Утас: 96651794
- 8 2009 оны "HUMMER H2" зарна. Утас: 91777877
- 9 2008 оны "LX570" зарна. Үнэ: 60 сая Утас: 99111468

КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- 1 IPICO брэндийн i9 загварын супер мини прожектор зарна. Утас: 96012938
- 2 Тог бага зарцуулдаг халаагчыг ширхэгээр болон бөөнөөр худалдаалана. Утас: 88153366
- 3 Таван талаасаа халдаг, тэнн зарна. Утас: 88153366
- 4 Таван өнгийн сонголттой хүүхдийн машин шинээр ирлээ. 2016 оны шинэ загварын машин Лед гэрэлтэй mp3-тай өөрөө явна. 21 дүгээр хороолоос үзэж болно. хүргэлт 2000. Утас: 99135845
- 5 "Sony Vaio core i5" notebook зарна. Үнэ: 500.000 Утас: 88102740
- 6 Sony 15.6 Core I7 560-d зарна. model VPCF133FX Intel(R) Core(TM)i7 Q740 1.70 ghz Ram 4g hhd 500gb Display 15.6 inch numlock Утас: 88771767

ҮЛ ХӨДЛӨХ

- 1 БЗД өгөөмөр сэлбэгийн захын зүүн хойно байрлах нарлаг өргөө хотхоны үйлчилгээний зориулалттай 1 давхарт 107м2 бүх төрлийн үйлчилгээ хийх боломжтой талбай түрээслүүлнэ. Утас: 90177181 , 99905286
- 2 Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. Утас: 99466494
- 3 Модны 2 зам дагуу байрлалтай 2 өрөө байр хямд зарна. Утас: 99289768
- 4 Урлан бүтээх төвийн хойно байрлалтай. "Хурд" констракшн барьсан, ванн, жорлон тусдаа бүх цонх наран тал руугаа харсан байр. Том тагттай. Утас: 91181618
- 5 Хан-Уул дүүрэгт Peace town хотхонд 58.92м.кв байр зарна машин оролцуулж болно. Утас: 99097639
- 6 Модны 2-т угсармалын гурван өрөө байр зарна. Утас: 99105070
- 7 2 өрөө үйлчилгээ явуулах боломжтой байр зарна БЗД 8-р хороо Баянзүрх хотхон 108-р байрны 1-р давхарт дэлгүүр, сургалт, цэцэрлэг, үйлчилгээ явуулах боломжтой 43 мкв 2 өрөө байр хямд зарна. Хаяг: Офицерын тойргоос уруулаад Баянзүрх хотхон 108-р байр Утас: 80612065

НОМ, ХЭВЛЭЛ

- 1 Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна. Утас: 99144154
- 2 Хуучин номнууд зарна. Утас: 94640105
- 3 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна. Утас: 99153637
- 4 Ээж ба хүүхэд ном зарна. Утас: 99089401
- 5 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтлэсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна. Утас: 99625921
- 6 Монголын залуучуудад өөрийн үндэсний зан заншил, ухамсар, ёс суртахууныхаа үнэт зүйлийг гээлгүй зөв хослуулан авч явахыг зөв ухамсарлан ойлгуулах энгийн хялбараар илэрхийлж чадсан “Монгол хүний хөгжил төлөвшлийн ДЭЭД УХААН” ном уншигчдын гар дээр очиж байна. Утас: 98111029
- 7 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна. Утас: 99153637

ЦАХИЛГААН БАРАА

- 1 Шинэ технологийн керамик хошуутай, секундийн дотор 370 градус /цельс/ хуртгал хална. ColdHeat керамик хошуу нь дулааны 98% ашигладаг ба энэ нь ердийн гагнуурын алхнаас 20 дахин илүү үр ашигтай. Бага эрчим хүчнээс маш их дулаан гаргана. 4 ширхэг хуруу батарей ашиглана. Утас: 96012938 , 88512938
- 2 Германаас ирсэн мотор (generator) зарна. Цоо шинэ. Утас: 99093469
- 3 Нийтийн хоолны бизнест чухал хэрэгцээтэй тоног төхөөрөмж болох хөргүүртэй шүүгээ зарна. Дээд талдаа салад, ногоо зэргийг хөргөлтийн шаардлагын дагуу хадгалах наймган секцтэй, доод талдаа хөргөгчтэй шүүгээтэй. Утас: 75752020

ГАР УТАС

- 1 Ухаалаг цагтай байхад угсаа хаях, дуудлага сонсохгүй байх асуудалгүй боллоо. GSM сүлжээ SIM карт дэмжинэ. Дурын дугаар руу залгах дуудлага хүлээн авах боломжтой. Мессеж бичих, сэрүүдлэг, цаг, pedometer, тооны машин гэх мэт олон үйлдэлтэй. Утас: 96012938 , 99818832
- 2 АНУ-аас ирсэн "iPhone 6" 16GB gold, gray. Үнэ: 1.250.000 шинэ, задлаагүй. Утас: 99127331
- 3 АНУ-аас ирсэн цоо шинэ задлаагүй "Factory Unlocked Iphone 6s" 16gb хар өнгөтэй утас зарна. Үнэ: 1.800.000 -гаас хямдраад 1.700.000 Утас: 99085424

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Лавлах

ҮЙЛ ЯВДАЛ Шинэ номын сантай боллоо

Б.Баярмаа
ЗГМ

Монголын залуучуудын холбооны дэргэд оюутан, залууст зориулсан номын сан нээгдлээ. БНСУ-ын ЭСЯ-наас санхүүжүүлсэн тус номын сан үнэгүй интернэтэд холбогдсон суурин компьютерууд, iPad цахим ном уншигчтай. Мөн WI-FI-тай уншлагын болон лекцийн танхимуудтай юм байна.

Номын санд одоогоор солонгос хэл дээрх уран зохиолын болон бусад салбар шинжлэх ухааны 500 орчим ном, сэтгүүлийг байршуулжээ. Цаашид номын санг өргөжүүлж, соёлын өдөрлөг зохион байгуулж, БНСУ-д суралцах боломжуудын талаар цуврал лекц зохион байгуулах юм байна. [ЗГМ]

ХЭРЭГ ЗӨРЧИЛ Малын хулгай буурчээ

Малын хулгайн хэрэг гурван жил дараалан буурсан талаар Мөрдөн байцаах газрын Хулгайлах гэмт хэрэг мөрдөх хэлтсээс мэдээллээ. Үүний 67.4 хувь нь нийслэл, 32.6 хувь нь орон нутгийнх байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.8 хувиар буурсан үзүүлэлт аж.

Малын хулгайг бууруулахаар 13 аймагт мал хулгайлах гэмт хэрэгтэй гэмцэх хэсэг байгуулсан юм. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД Ясны сийрэгжилтийг үнэгүй оношилно

“Монхимо” судалгааны төв Ясны хугарлын эрдэлийг бууруулах хөтөлбөр боловсруулжээ. Уг хөтөлбөрийн хүрээнд “Мед Траума” эмнэлэгт ясны сийрэгжилтийн оношилгоо хийж байна. Иргэд ясны хугарлаа харуулсан рентген эсвэл томографийн зургаа үзүүлж үнэгүй оношлуулах боломжтой аж.

Ясны бэртэл, гэмтэл гадны нөлөөллөөс үүсдэг ч тухайн хүний ясны сийрэгжилтийн хэмжээнээс давхар шалтгаалдаг байна. Ясны нягтаршил өчүүхэн төдий муудахад хугарах эрсдэл нэмэгдэж, төдий хэмжээгээр эдгэрэх хугацаа нь удааширдаг аж. Тиймээс сийрэгжилтийн хэмжээг тогтоож, тохирох эмчилгээ хийх шаардлагатай болдог. [ЗГМ]

ЗӨВЛӨГӨӨ Өд, сөдөн хувцсаа угаах арга

Өд, сөдөн хувцсыг цэвэрлэх амаргүй. Тиймээс бөөгнөрүүлэхгүй хэрхэн угаах зөвлөгөөг хүргэж байна.

- Угаахаасаа өмнө хувцсаа товчилж, цахилгаандаарай.
- Өөр хувцастай холихгүй тусад нь угаах хэрэгтэй.
- Дараа нь угаалгын машины хамгийн зөөлөн горимыг сонгож, 30 хэмийн халуун усанд угаах хамгийн тохиромжтой.
- Угаах үедээ өд, сөдийг хугалахгүйн тулд тусгай зөөлөн бөмбөг эсвэл теннисний бөмбөг хийж болно.
- Мөн өлгүүрт өлгөж, сэрүүн газар хатаахаас гадна үе үе сэгсэрч, өд, сөдийг нь хөвсгийлгөөрэй. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

08.00	MNB 09.10 "Дөлгөөн Дон" уран сайхны кино	Bloomberg 07.00 "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	Боловсрол 09.45 "Монголчууд ХХ зууны эхэнд" нэвтрүүлэг	Монгол ТВ 09.30 "Тог тог" хүүхдийн нэвтрүүлэг
12.00	12.00 "Амьдралын жор" нэвтрүүлэг	12.00 "Бизнесийн хэмнэл"	11.15 "Найзууд" ОАК 235, 236 дугаар анги	11.40 "Хар хаймран гутал" хүүхэдэйн кино 75-р анги
14.00	13.30 "Ирээдүйд илгээх захидал"	15.00 "Бизнесийн төв цэг" давталт	14.05 "Зөв үнийг таа" шоу нэвтрүүлэг	15.00 "Өөрчлөлт" 1 дүгээр бүлэг, 19 дүгээр хэсэг
18.00	16.50 Үндэсний шилдэг 21 дууны жагсаалт	17.00 "Bloomberg Surveillance" шууд орчуулгын хөтөлбөр	18.30 "Score news" мэдээллийн хөтөлбөр	18.00 "Наашаа цаашаа"
20.00	19.30 Инновацийн шийдэл	20.30 "Удирдагчид Лакуатай хамт" нэвтрүүлэг	20.40 "80 саяын уналт" нэвтрүүлэг	20.00 "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
22.00	21.10 "Энд гарц байна: Ажлын гараа"	22.05 "Блумбергийн нүүрсний форум" цуврал	22.00 "Доктор Хэн" ОАК 7 дугаар бүлэг 7 дугаар анги	23.30 Үдшийн мэдээ

ОНЦЛОХ ҮЗВЭР Б.Амархүүгийн гурав дахь ТОГЛОЛТ



ОХУ-ын Буриад улсын Гавьяат жүжигчин, Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан дуучин Б.Амархүү ирэх сарын 9-ний 19.00 цагт тоглолтоо хийх гэж байна. Энэ нь түүний гурав дахь бие даасан тоглолт юм. Монгол бөхийн өргөөнд болох уг тоглолтын тасалбар 20 мянган төгрөгийн үнэтэй. Дуучин Б.Амархүү өнгөрсөн сард Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сайншанд, Өмнөговь зэрэг аймагт аялан тоглолтоо хийсэн юм. [ЗГМ]

ҮЗВЭР



Италийн хөгжмийн зохиолч Ж.Пуччинигийн "Тоска" дуурийг ирэх сарын 3-нд тоглоно. Үзэсгэлэнтэй хэдий ч гэнэн томоогүй Тоска бүсгүйн хайр дурлалын ээдрээг уг бүтээлээр үзүүлдэг.



Гэрэл зураг сонирхогч залуусын "Бидний өнцөг" үзэсгэлэн энэ сарын 2-нд нээлтээ хийнэ.



"Баянмонгол" жазз найрал хөгжмийн хамтлагийн "Movie swing" тоглолт ирэх сарын 2-нд болно. Алдартай киноны хөгжим, дуугаар дагасан энэхүү тоглолтыг хоёр дахь жилдээ зохион байгуулж байна. Тасалбарын үнэ 15 мянган төгрөг.



"Улаанбаатар цирк"-ийн жүжигчдийн тоглолт ирэх сарын 3-нд болох гэж байна. Уг тоглолтод Турк, Япон, ХБНГУ, Франц зэрэг олон оронд тоглосон шилдэг үзүүлбэрүүдээ толилуулана. Тоглолтыг 10 мянган төгрөгөөр үзээрэй.



Энэ сарын 2-нд анх удаа "Хагас нүцгэн урлаг" шоу-го зохион байгуулах гэж байна. Уг шоу "Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн төлөө" уриан дор зохион байгуулах юм.



Ковер дуучин Анух, Очмаа нарын тоглолт ирэх сарын 3-нд болно. Тэд тоглолтын орлогоо "Ид шидийн орон" хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийг барих газрыг худалдаж авахад хандивлах юм. Тоглолтын тасалбар 10 мянган төгрөгийн үнэтэй.



Шинэ жилийн баярыг угтсан "Women ex-ро 2017" үзэсгэлэн худалдаа ирэх сарын 3, 4-нд болох гэж байна. Энэ үеэр монгол дизайнеруудын гоёлын даашинзны загварын шоу үзүүлэх юм.

ЗУРХАЙ




Билгийн тооллын 1

Өвлийн дунд цагаан хулгана сарын зургаан цагаан мэнгэтэй улаан луу өдөр
Үс засуулбал: Нас ахар болно
Наран ургах, шингээ: 08.19-17.09
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Өтлөх үрхэхүй

Ардын тооллын арваннэг-дүгээр сарын 30, Буд гараг. Билгийн тооллын 1. Эрхтний тэнгэрт одтой, улаан луу өдөр.

Өдрийн наран 08.19 цагт мандаж, 17.09 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр эе эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



гүрэн
 10. Архийг нэрж гаргасан идээ
 11. Дуу хөгжмийн ерөнхий ая

ХӨНДЛӨНГӨӨР:

2. Автомашины ослоор нас барсан Английн үзэсгэлэнт гүнж
4. Эвтэй дөрвөн амьтан
7. Оцон шувууны нутаг
8. Үндэсний баяр наадамд 3 удаа түрүүлсэн бөхөд олгодог байсан цол
12. Нэгэн төрлийн даам

13. Говийн догшин шороон шуурга
14. Монголчуудын уламжлалт бэлгэдлийн тоо

Өмнөх дугаарын хариу / 11.29



ЗГМ: СҮДОКУ

			4			6
				7		
5	8			9	3	
	4	3				
7		8				
2			1			7
	6	5		2		4
		4		2		3
				3		5

3	4	6	7	5	1	2	9	8
7	2	8	4	6	9	5	1	3
5	9	1	8	2	3	4	6	7
4	3	7	1	9	8	6	2	5
6	1	5	2	3	7	8	4	9
2	8	9	5	4	6	3	7	1
9	5	4	3	1	2	7	8	6
8	6	2	9	7	5	1	3	4
1	7	3	6	8	4	9	5	2

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

XI.30
 -12° | 8 м/с
 -17° | 6 м/с
 Үүл багасна

XII.1
 -8° | 8 м/с
 -19° | 5 м/с
 Багавтар үүлтэй

XII.2
 -6° | 6 м/с
 -16° | 7 м/с
 Үүлшинэ

XII.3
 -8° | 7 м/с
 -16° | 5 м/с
 Үүлшинэ

XII.4
 -13° | 7 м/с
 -17° | 9 м/с
 Үүлшинэ



[ЗГМ]

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" Сонины онлайн захиалга ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН.....

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]

ВАЛҮТЫН ЗАРЛАСАН ХАНЦ

Долларын ханшийн тасралтгүй өсөлт нь

Чангарчихаад яасан буудаггүй хог вэ?

Н.Эрдэнэбаяр, Э.Тамир ©

ГАЛТ ТЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Москва-УБ	23.45	06.50
Бээжин-Москва	11.22	13.58
Эрхүү-УБ	16.32	06.53
УБ-Эрхүү	20.45	02.15
Сайншанд-УБ	21.15	07.15
УБ-Сайншанд	10.10	19.48
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Токио	08.45	13.40
Токио-УБ	15.30	20.25
УБ-Бээжин	08.15	10.30
Бээжин-УБ	11.30	14.00
УБ-Москва	08.00	09.50
Москва-УБ	19.00	06.15
Москва-Берлин	11.00	11.50
Берлин-Москва	13.15	18.00
УБ-Ханбумбат	07.20	08.30
Ханбумбат-УБ	09.20	10.25

Байршил



Mongolian Property Management Group

Real Estate Service · Real Estate Appraiser · Real Estate Developer

Address: Sukhbaatar district, Naryn zam 56, Zamiin tsagdaa,
Tsoma Office, 601, Ulaanbaatar, Mongolia
Phone: +976 8806 8207, +976 8800 3620
www.mpmgroup.mn



BELLA VISTA
Хэмжээ: 165 м2
Өрөө: 3
Граж: 1 машины гражтай
Үнэ: 4,000,000 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



GALAXY TOWER
Хэмжээ: 737 м2
Өрөө:
Граж: 40 машины зогсоол
Үнэ: 2550\$ /худалдана/
Хаяг: ХУД



RIVER GARDEN
Хэмжээ: 179,8 м2
Өрөө: /4 унтлагын өрөө/
Граж: 2 машины зогсоол
Үнэ: 3,900,000 ₮ /худалдана/
Хаяг: ХУД, Маршалын гүүр



JAPAN TOWN, C4 APARTMENT
Хэмжээ: 138.52 мкв талбайтай
Граж: 1 машины зогсоолтой
Өрөө: 3 өрөө байр түрээслэнэ
Үнэ: 2400\$
Хаяг: ХУД



ОДДЫН ХОТХОН
Хэмжээ: 119 м2
Өрөө: 4
Граж: 2 /20 м2/
Үнэ: 2,500,000 м2 ₮ /түрээс/
Хаяг: ХУД



ЗАЙСАНГИЙН ОРГИЛ
Хэмжээ: 136,06 м2
Өрөө: 5 өрөө байрыг гадаадын иргэнд яаралтай түрээслүүлнэ.
Үнэ: 2000\$
Хаяг: ХУД



SEOUL ROYAL COUNTY
Хэмжээ: 200 м2
Өрөө: 4 /3 давхарт/
Үнэ: 3000 \$
Граж: 2
Хаяг: ХУД, Зайсан



EASTERN PLAZA
Хэмжээ: 150-300 м2
Зориулалт: Оффис үйлчилгээ
Граж: Машины зогсоолтой
Үнэ: Зах зээлийн үнээр түрээслүүлэх болон худалдана
Хаяг: Хотын А зэрэглэлийн бүс болох СБД, Сөүлийн гудамж, NARAN Mall их дэлгүүрийн чанх хойно.
Утас: 98995225, 90112555



BUDDHA VISTA
Хэмжээ: 122
Өрөө: 4
Граж:
Үнэ: 750 сая ₮ /худалдана/
Хаяг: ХУД, Зайсан



НҮХТ
Хэмжээ: 900 м2 /газар/
Хэмжээ: 250 м2 /зуслангийн байшин/
Граж: 3 машины зогсоол
Үнэ: 500,000,000 ₮



BRAUNHAUS
Хэмжээ: 100 м2
Өрөө: /2 унтлагын өрөө/
Граж:
Үнэ: 200,000 \$ /худалдана/
Хаяг: Сөүлийн гудамж



ROMANA RESIDENCE
Хэмжээ: Цоо шинэ 66мкв талбайтай
Өрөө: 2 өрөө байр түрээслүүлнэ
Үнэ: 1000\$
Хаяг: ХУД



ҮЛ ХӨДЛӨХИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИЛҮҮ ХҮРТЭЭМЖТЭЙ ИЛҮҮ ХЯМДААР

[ЗГМ]

Та үл хөдлөх хөрөнгийн мэдээллээ байршуулахыг хүсвэл доорх утсаар холбогдоно уу.

Утас: 99903584, 99903581



СЭЛБЭ ХОТХОН
Хэмжээ: 172 м2
Өрөө: 4 /пентхаус/
Граж: 2 машины зогсоол
Үнэ: 3,0 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: "Орчлон 1" сургууль



REGENCY RESIDENCE
Хэмжээ: 165 м2
Өрөө: /3 унтлагын өрөө/
Граж: машины зогсоолтой
Үнэ: 335,000 \$ /худалдана/
Хаяг: БЗД, 13 дугаар хороо



BLUE SKY
Хэмжээ: 118 м2
Өрөө: 3
Граж:
Үнэ: 1,500,000 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



RE/MAX Mongolia

Танд зориулсан үл хөдлөх хөрөнгийг эндээс...

Хаяг: Баянзүрх дүүрэг, 26 хороо Их хүрээ гудамж,
Парк сайд төвийн 3 давхарт
Утас: 77073399, 94093390, 94043390
http://www.remax.mn



SEOUL PLAZA
А зэрэглэлд байршилтай, нийт 11 давхар, 8800 м2 талбайтай, 1-4 давхарт: Өндөр зэрэглэлийн худалдаа, үйлчилгээний төв 5-9 давхарт: Оффис 10-11 давхарт: Ресторан, лоунж 2016 оны зургадугаар сард бүрэн ашиглалтанд орно.
Хаяг: БГД, "Сөүл плаза" бизнес төв



MD CENTER
Хэмжээ: 2380 м2
Өрөө: 3 давхар, 2 жигүүр
Граж: 30-40 машины ил зогсоол 20 машины дулаан граж
Үнэ: 2,500,000 ₮ /худалдана/
Хаяг: ХУД, 15-р хороо



ЦЭЛМЭГ ТӨВ
Хэмжээ: 9 давхар оффис
Өрөө: тус бүр 624 м2
Граж: ил зогсоол
Үнэ: 60,000-70,000 ₮ /түрээслэнэ/
2200-2900 \$ /худалдана/
Хаяг: СБД, 1-р хороо



9 ЭРДЭНЭ
Хэмжээ: 642 айлын орон сууц
Өрөө: 2-3
Граж:
Үнэ:
Хаяг: БГД 3-р хороо



ПАРКСАЙД РЕЗИДЕНС
Хэмжээ: 52.58-178.47 м2
Өрөө: 2-5
Граж:
Үнэ: 2,600,000-3,000,000 ₮
Хаяг: БЗД



RESIDENCE 60
Хэмжээ:
Өрөө: 1-5
Граж: дулаан зогсоол
Үнэ: 1750-2650 \$
Хаяг: БЗД, 4-р хороо



ИХ МОНГОЛ РЕЗИДЕНС
Хэмжээ: 195 айлын
Өрөө: 3-4 /сонголт/
Граж: Газар доорх байгууламж бүхий 165 граж
Хаяг: БЗД



BLUE GEM-4
Хэмжээ: 15 давхар
Өрөө: Сонголттой
Граж: байгаа
Үнэ: 2,800,000-3,200,000 ₮
Хаяг: БГД, UB Place-ын хажууд



ЗАЙСАН ГОЛДЕН ВИЛЛ
Хэмжээ: 100 айлын орон сууц
Өрөө: 3-5 /сонголттой/
Граж: 150 автомашины зогсоол
Үнэ: 3,500,000-3,800,000 ₮
Хаяг: ХУД, 11-р хороо



NARAN PLACE
Хэмжээ: 120 айлын тохилог сууц
Өрөө: 2-5 /сонголттой/
Граж: давхар зогсоол /төлөвлөсөн/
Үнэ:
Хаяг: БЗД, 6-р хороо



BBM©

Компьютер үйлчлүүлэгчийн сэтгэлийг ойлгодог болно

Ральф Аткинс

Швейцарь нь хил дамнансан хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг. Тус улсын санхүүгийн үйлдвэрлэл өнгөрсөн онд албан байгууллага, компани, чинээлэг эрхмүүдийн хөрөнгийг оролцуулаад нийт 6.6 их наяд швейцарь франкаар хэмжигдэж байлаа.

Тиймээс Швейцарийн банкны эзэд дэлхийн санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг өөрчлөх технологийн хувьсгалыг сонирхох нь ихэссээр. Автомашин үйлдвэрлэлийн салбарт автомат жолоодлоготой машин үүсэж буйн адилаар үйлчлүүлэгчийнхээ хөрөнгийн менежментийг бүхэлд нь компьютерт даатгах зөгнөлт санаа ч энэхүү технологийн хувьсгалд багтдаг.

Хөндлөнгийн нэгэнд энэхүү санаа нь соёлын зөрчил үүсгэж буй мэт санагдаж болох. Учир нь Швейцарийн банкууд хуучин уламжлалаа хадгалж, хувь хүнд биечлэн үзүүлэх үйлчилгээнд анхаарч, нууцлалыг чанд сахихыг эрмэлздэг. Гэхдээ татвараас зайлсхийх зорилготой үйлчлүүлэгчдийг дэлхий даяар мөрдөн шалгах болсонтой уялдан нууцлал сахих журам сүүлийн арван жилд өөрчлөгдсөн.

Швейцарь нь хүний оронд сэтгэж, хүнээс илүү ажиллах чадвартай компьютерийн хэрэглээг нэн түрүүн анхаарч эхэлсэн нь зарим талаар санаанд оромгүй зүйл. Чухам энэ салбарт анхдагчийн нэг нь Швейцарийн италиар ярьдаг бүс нутаг дахь Луганогийн их сургуулийн хиймэл оюун ухааны салбарын

профессор Юрген Шмидхубер. Тэрбээр Google-ийн ашигладаг хэл яриа таних цогц систем хөгжүүлэх ажил эрхэлж байгаа юм. Хэл яриа таньдаг шилдэг систем, жишээ нь рестораны шуугиан дундаас ч хүний хэлсэн үгийг ялгаж ойлгодог байх ёстой.

Сая сая баримтаас суралцах чадвартай хүний уураг тархийг дуурайлгасан мэдрэлийн цогц сүлжээний ажиллах зарчмыг ноён Шмидхубер энэ сард Цюрих хотноо болсон мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежерүүдийн хуралдаан дээр тайлбарласан юм. Ард болж буй шуугиан дундаас ч яриа ялган ойлгох чадвар бүхий ийм сүлжээг санхүүгийн салбарт ашиглаж болно хэмээн эрдэмтэн үзэж байна.

Иймэрхүү санааг амьдралд хэрэгжүүлэх талаар сүүлийн хэдэн арван жилийн турш хармайсаар ирлээ. Хиймэл оюун ухаан автомашинд эрчимтэй нэвтэрч байгаа. Харин хиймэл оюуныг санхүүгийн салбарт туршсан хувийн хөрөнгө оруулалтын сангийн менежерүүд бүтэл муутай хэвээр.

Гэтэл компьютерын хүчин чадал шуурхай өсөж, “Гүн суралцагч” систем хэрэглээнд нэвтрэх хэрээр шинэ үеийн мэдрэлийн сүлжээ хөгжсөөр хөрөнгө оруулалт, банкны үйлдвэрлэлд хүнийг халах гэрхүү эргэлтийн цогт ирчихлээ хэмээн профессор Шмидхубер зэрэг эрдэмтэд үзэж байна.

“Хүний хийж чадаж байгаа бүхнийг хиймэл оюун бүр ч илүү чадна” хэмээн профессор

Шмидхубер Financial Times-д өгүүлсэн юм. Гэхдээ чаддаг болтол өчнөөн аз туршилт, бүтэлгүй явдал хүлээж байгааг ч эрдэмтэн анхаарууллаа.

Технологийн дэвшил амьдрах аргад нь заналхийлнэ гэсэн айдас Швейцарийн банкны эздэд байхгүй. Харин ч зардлаа багасгахын тулд дэлхийн даяар банк санхүүгийн үйлчилгээг автоматжуулж, хөрөнгө оруулалтын суурь үйлчилгээнд зөвхөн “Робот зөвлөгөө” өгдөг болгох зорилт тавьж байна. Юутай ч банкууд компьютерын хүчин чадлыг хүн орлоход бус, хүнд туслахад ашиглана.

Зохицуулалтын болон санхүү, тооцооны асуудлыг оролцуулаад шийдвэрлэх ёстой бэрхшээл олон байгааг хөрөнгө оруулалтын менежерүүд анхаарууллаа. Аварга хөрөнгийг одоо ч цөөн хэдхэн хүн эрхлэн хөтөлж болоод байгаа учраас ирээдүйн болзошгүй хэмнэлт төдийлэн их байж чадахгүй. Компьютерын хэрэглээтэй уялдан үүсдэг Flash Crash буюу богино хугацаанд нисэх онгоцыг өнгөрсөн арван-туудыг задлан шинжлэх замаар ажилладаг оюун ухаан Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон зэрэг үрэгдчилэн таамаглах аргагүй үйл явдал хэрхэн хандах нь судлах ёстой зүйл болж байна. Геополитикийн тогтворгүй нөхцөлд мөнгийг нь Швейцарь дахь танил банкны эзэн нь хадгалж байгааг мэдэж

байвал дэлхийн баячууд сэтгэл амар байх болно.

Ийм нөхцөлийг хүртэл уян хатан зохицуулж болно хэмээн профессор үзэж байна. Мэдрэлийн сүлжээ нь цутгаж буй баримтуудад тулгуурлан улс төрийн үйл явдлыг задлан шинжилж, нөхцөл байдалд тохируулан арилжаа хийнэ. Мөн урьд өмнө нь тохиолдож байгаагүй үйл явдлыг ч урьдчилан харж чадна.

Гэхдээ л өнгөрсөн долоо хоногт Цюрих хотноо болсон хөрөнгө оруулалтын менежерүүдийн хуралдаанд оролцогсод профессорын үгэнд төдийлэн итгэсэнгүй. Тус хуралдаанд оролцогчдын талаас илүү нь хиймэл оюун ухаан арилжааны ажилд хүний туслагч болж чадна гэж үзэв. Харин 10-хан хувь нь хиймэл оюун ухаан хөрөнгийн менежмент эрхлэх чадвартайд итгэсэн юм.

Татвар төлөх журамд зохицсон шинэ нөхцөлд ч Швейцарийн банкууд хувь хүнд тухайлан хандсан арга барилынхаа ачаар шэцлэгээр байна. Юутай ч үйлчлүүлэгчийнхээ хувийн онцлогт тохируулан харьцаж, мөнгийг нь компьютер эрхлэн хөтөлж байгааг хэлж ч зүрхлэхгүй гэдгээ Швейцарийн нэгэн хувийн банкны эзэн тайлбарлав.

Компьютерууд камер ашиглан үйлчлүүлэгчийнхээ сэтгэлийн хөдөлгөөнийг тодорхойлох үндсэн дээр харьцах талаар профессор Шмидхубер өгүүлсэн нь мэдээж. Ийм чадвартай боллоо ч компьютер Швейцарийн банкны эзэн шиг байж чадахгүй биз ээ.

Европын шүүх Uber-ийн хэргийг эцэслэн шийдвэрлэнэ

Данкэн Робинсон

Uber чинь тээврийн компани уу, дижитал үйлчилгээ эрхлэгч үү? Европын шүүх мягмар гарагт чухам энэ асуултын хариуг олохоор эзхэж байна. Тус шүүхээс хэлэлцэх заргын явцад 63 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй Ride-hailing буюу такси дуудах аппликэйшн, Sharing economy буюу хуваалцах эдийн засаг гэгдэж буй эдийн засгийн шинэ хандлагыг бүхэлд нь авч үзэх юм.

Хэрвээ Uber дан дижитал үйлчилгээ эрхлэгч мөн бол Европын холбоо даяар бизнес эрхлэх эрхтэй. Хэрвээ Uber ердийн тээврийн компани бол илүү нарийн зохицуулалт шаардлагатай төдийгүй Европын холбооны гишүүн 28 улс бүгд тус компанийг хориглож мэднэ.

Европын холбооны шүүхээс гаргах шийдвэр нь ажилчдыг хэрэглэгчтэй нь шууд холбож өгдөг Airbnb, Deliveroo, Hassle зэрэг интернэт компаниудад нөлөөлнө. Ийм компаниудын үйл ажиллагааг зогсоох шаардлагыг зохицуулах байгууллагууд урьд нь ч тавьж байв.

“Унадаг дугуйн тээвэр, гэр цэвэрлэх, Ikea-гийн мебель угсрах зэрэг хуваалцах эдийн засгийн бусад салбарт ч нөлөөлөх биз. Европ тив нь ийм үйлчилгээ эрхэлдэг компаниудын хувьд маш чухал зах зээл учраас хуулийн шинэ зохицуулалт, үндсэн өөрчлөлт хийгдэх эхлэл болно” хэмээн Sharing Economy UK байгууллагыг үндэслэгч Дебби Воссков тайлбарлав.

Барселонаос Европын холбооны хууль зүйн дээд байгууллагад мэдүүлсэн уг заргатай холбогдуулан гаргах шийдвэр хоёрдмол утгатай байж болохгүй. Uber-ийг “Мэдээллийн нийгмийн үйлчилгээ” эрхлэгчийн зэрэгцээ тээврийн компани мөн хэмээн үзэх тохиолдолд тус холбоонд ажилладаг онлайн зуучлагчдын ажиллагаа ч хууль зүйн хувьд будлиантай болж хувирна. Европын холбоонд дижитал бизнесийг “Мэдээллийн нийгмийн үйлчилгээ” гэсэн өвөрмөц нэр томъёогоор тодорхойлодог.

Онолын хувьд үйлчилгээний компаниуд нийт Европын холбоо даяар чөлөөтэй ажиллах эрхтэй. Гэхдээ тээвэр зэрэг зарим салбарт тухайн гишүүн улсын хуулийн зохицуулалт шаардлагатай. Гэтэл Uber, Airbnb зэрэг тодорхой үйлчилгээг шууд эрхэлдэггүй ч хялбар дөхөм болгодог компани Европын холбооны хууль журамд зохицож өгөхгүй байгаа юм.

“Программ хангамжийг такси, зочид буудал болгон авч үзэх нь утгагүй төдийгүй хэрэглэгчийг хамгаалах, эдийн засгийг эрчимжүүлэхэд ч уршигтай” хэмээн технологийн үйлдвэрлэлийн лобби групп Компьютер, холбооны үйлдвэрлэлийн холбооны (CCIA) дэд

ерөнхийлөгч Жеймс Уотерворт тайлбарлав.

Гэтэл тухайн салбарт өрсөлдөгчдөд үйлчилдэг хууль зүйн зохицуулалтаас мултарсаар өдий хүрсэн дээрх компаниуд шударга бусаар ноёрхох байр суурьтай болж байгааг шүүмжлэх явдал ихэслээ. Калифорнид байрладаг Uber компани 2011 онд Европ тивд ажиллаж эхэлсэн үеэс тус старт-ап компани, Европын зохицуулах байгууллагууд, өрсөлдөгч такси компаниудын хооронд бүтэн таван жил үргэлжилж буй зарга ийнхүү шийдвэрлэгдэх дөхлөө. Эдүгээ такси дуудах аппликэйшний үйлчилгээг ХБНГУ, Франц, Итали, Бельги, Нидерланд, Испани улсад тодорхой хэмжээгээр хязгаарлах буюу хориглоод байгаа. Uber-ийн Амстердам дахь төв байрыг байнга шалган нэгждэг болсон. Мөн Франц дахь салбарын захирлууд нь шоронд хорих ял заналхийлж байна.

Uber компани ч сүүлийн хоёр жилд арга барилаа өөрчилж, Европын холбооны улсуудын эрх баригчдыг аргалах бус, хамтран ажиллахыг илүүд үзэх боллоо. Эдүгээ Uber нь Европын холбооны гишүүн 28 улсын 21-т нь үйл ажиллагаа явуулж байна. Уг 21 улсын нэг Бельгид тус компанийн жолооч нарыг торгохоор саяхан болтол сүрдүүлж байв. Харин Uber-ийг дэмжигчид шүүхээс гарах шийдвэрт сэтгэл зовохгүй байгаа юм. “Айхтар буруутлаа гэхэд одоогийн байдал хэвээр үргэлжлэх биз” хэмээн Uber-ийн хэрэгт ойр эх сурвалж өгүүлэв.

Uber-ээс болон Европын холбооны гишүүн улсуудаас мэдүүлэх тодорхой тайлбарыг Европын шүүхийн 15 шүүгч авч хэлэлцэнэ. АНУ-ын голлох интернэт компаниуд бүгд ажилладаг Ирланд ч такси дуудах аппликэйшнийг хуулийн нарийн зохицуулалтад хамруулах үүднээс Uber-ийг тээврийн компанид ангилахыг уриалж байгаа.

Харин Финланд зэрэг дижитал үйлчилгээг эрхэмлэгч зарим жижиг улс, Европын комисс Uber-ийн тайлбарыг ойлгож хүлээн авна хэмээн шинжээчид таамаглаж байна. Европын холбооны гүйцэтгэгч байгууллага нь Apple, Microsoft, Google зэрэг компаниудыг холбоотой өрсөлдөөний хэрэгт хатуу байр суурь баримталдаг. Гэхдээ Uber-ийн хэрэгт тус байгууллага харьцангуй зөөлөн хандаж, гишүүн улсуудын хууль зүйн зохицуулалтад хөнгөн өөрчлөлт оруулах төдийгөөр шийдвэрлэх байх хэмээн зарим нь найдаж байна.

“Европын улстөрчид шүүхээр бүхнийг шийдүүлснээс хууль зүйн тогтолцоогоо өөрчлөхөд илүүтэй анхаарах нь чухал” хэмээн ноён Воссков өгүүлж байлаа.

Бээжин Сингапурт эсэргүүцэл илэрхийлэв

Чарльз Кловвер, Живан Васагар

Сингапурын байлдааны есон машиныг Хонконгод хурааж авсны дараахан тус арал улсад БНХАУ албан ёсоор эсэргүүцэл илэрхийллээ. Уг эсэргүүцэл нь Вашингтоны ойрын түнш Сингапураас Тайваньтай тогтоосон цэргийн хэлхээ холбоонд БНХАУ-ын эрх баригчид сэтгэл түгшиж буйн илрэл болов.

Тайваниас Сингапур хүрэх ёстой Тетгех хуягласан машинуудыг Хонконгийн гааль “Хяналтад байх ёстой сэжиг бүхий бараа” гэсэн шалтгаанаар өнгөрсөн долоо хоногт саатуулжээ. “БНХАУ энэ хэргийн талаар хэдийнэ Сингапурын талд мэдэгдэл хүргүүлсэн” хэмээн Хятадын Гадаад хэргийн яамны

төлөөлөгч Гэн Шуан даваа гарагт мэдэгдлээ. Сингапур нь Хонконгийн зохих хууль журмыг даган мөрдөж, орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах ёстой гэсэн шаардлагыг Бээжингээс тавьсан тухай төлөөлөгч уламжлав.

Уг маргаан нь Бээжин Азийн хөршүүдээ улам бүр сонор соргог хянах болсныг харуулж байна. БНХАУ нь олон арван жилийн турш гадаад бодлогодоо хүлэээнх байр суурь баримталж ирсэн. Харин эдүгээ тус улс Филиппин, Тайланд зэрэг АНУ-ын холбоотнуудтай шүүхээр заргалдаж, Сингапур, Өмнөд Солонгос зэрэг Вашингтоны түншүүдэд шахалт үзүүлдэг боллоо.

Сингапур нь өнгөрсөн оноос

АНУ-тай цэргийн хамтын ажиллагаагаа бэхжүүлж, хүмүүнлэгийн тусламж, гамшгаас хамгаалах, кибер аюулгүй байдлын салбарт хамтран ажиллахаар тохиролцсон. Тус улс АНУ-ын Poseidon тагнуулын нисэх онгоцыг өнгөрсөн арванхоёрдугаар сараас эхлэн нутаг дэвсгэртээ байршуулахыг зөвшөөрчээ.

Сингапур нь БНХАУ болон тусгаар засаг захиргаат Тайванийн хоорондын зөрчилд олон арван жилийн турш төвийг сахих байр сууринаас хандаж иржээ. Мөн БНХАУ, Тайванийн удирдагчдын уулзалтыг ч нутагтаа зохион байгуулсан удаатай. Гэвч арал улс саяхнаас эх газрын Хятадын эсэргүүцлийг үл харгалзан Тайваньтай

цэргийн салбарт харилцаагаа бэхжүүлж эхэлсэн юм.

Дээр өгүүлсэн хуягт машинууд нь Тайваньд болсон цэргийн сургуулилтад Сингапурын цэргүүдийн ашигласан техник хэрэгсэл. Сингапур, Тайванийн хооронд 1975 онд байгуулсан батлан хамгаалах нууц хэлэлцээрийн дагуу хоёр тал тогтмол цэргийн сургуулилт хийдэг. Гэвч Сингапур, БНХАУ-ын хооронд 1990 онд дипломат харилцаа тогтсон цагаас уг сургуулилыг гэвчин өнгөрүүлж ирсэн Бээжин цаашид зүгээр харж суух тэсвэр алдсанаа мэдэгдэх болов.

Гааль дээр саатуулсан машинуудын талаар Сингапур хараахан хариу өгөөгүй. Харин Хонконгийн гаалийн алба

хэргийг мөрдөн шалгаж байгаагаа мэдэгдэв.

Үүний зэрэгцээ Хятадын төрийн мэдлийн Global Times сонинд даваа гарагт нийтэлсэн материалд Сингапурыг 2012 оноос Тайваньтай цэргийн хамтын ажиллагаагаа зогсоосон талаар дурджээ. “Гэтэл саяхан гааль дээр саатуулсан хуягт машинуудаас үзвэл Сингапур нь хоёр нүүрт бодлого баримталж байгаа бололтой” хэмээн уг сонин тайлбарлаж байна.

“Сингапур нь БНХАУ, АНУ-ын хооронд тэнцвэр барьж буй дүр эсгэдэг ч хэрэг дээрээ Вашингтоны талд зогсдог. Сингапурт цаашид Тайваньтай цэргийн талаар хамтран ажиллах ямар ч учир шалтгаан байхгүй” хэмээн тус сонин мэдэгдлээ.

Энэ онд Global Times сонин, Сингапурын хооронд маргаан дэгдсэн. Сингапур нь Венесуэлд болсон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний чуулга уулзалтын үеэр нутаг дэвсгэрийн маргаант Өмнөд Хятадын тэнгисийн асуудлаар шаардлагагүй дарамт үүсгэсэн хэмээн тус сонин арал улсыг буруутгасан юм. Уг зэмлэлийг Сингапур даруй няцаасан билээ.

Цэргийн нууц задрах эрсдэлтэй уялдуулан саатуулсан хуягт машинуудын хадгалалт хамгаалалтыг шалгах зорилгоор Сингапурын цэргийн тусгай баг бямба гарагт Хонконгод хүрэлцэн очсон. Есөн ширхэг хуягт машиныг Хонконгийн гаалийн агуулахад хадгалж байна.



Эдийн засаг

УУЛ УУРХАЙ

Доллар даллах найдвар

Ам.доллар дуудах
“хөзрөө” Засгийн
газар өнөөг хүртэл
дэлгэсэнгүй

Г.Байгал
@baigalZGM

Эргэлзээ төрүүлж буй өмнөд хөршийн зээл, итгэл нэмсэн “Стэнд бай”, Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр... Үүндээ энэ бүгд доллар даллах ганц зорилготой.

Манайд аж үйлдвэр сэргэж, өртөг шингэсэн үйлдвэрлэл тэлж буй нь үнэн. Гэвч унаж буй эдийн засгийг сэвхийгэл босгоход энэ салбарын хүч дутах нь сүүлийн хоёр жилд ажиглагдаж байна. Бидэнд уул уурхайгаас өөр сонголт үлдсэнгүй. Хүссэн, хүсээгүй уул уурхайг л түшиж Монголын эдийн засаг босох нь. Ялангуяа, хайгуул богино хугацаанд хөрөнгө оруулалт татах хамгийн боломжит бөгөөд найдвартай арга гэж эдийн засагчид дүгнэж байгаа юм.

Уг нь бодлого тодорхойлогчид үүнийг хэдийнэ мэдсэн. Тиймээс л таван жил зогсоосон хайгуулын тусгай зөвшөөрлийг өнгөрсөн оноос олгож эхэлсэн юм. Хууль, эрх зүйн хүрээнд үүнээс ч өмнө шинэчилсэн байдаг. Түүхий эдийн үнэ уруудаж, уул уурхайн орлого хумигдаж эхэлсэн тэр үе. 2014 оны долдугаар сарын 1-нд УИХ-аар Ашигт малтмалын тухай эрх зүйн нэмэлт өөрчлөлт оруулав. Төд удалгүй хэдхэн хоногийн дараа 28-ны Засгийн газрын хуралдаанаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоосон юм. Ингэж геологи, хайгуулын салбараар дамжуулан хөрөнгө оруулалт татах, эрдэс баялгийн нөөцөө нэмэгдүүлэх зорилгыг Засгийн газар тээж байлаа.

2015 оны нэгдүгээр сард Ашигт малтмалын газраас тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн. Үүний үр дүнд өнгөрсөн оны эцэс гэхэд хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо хоёр дахин нэмэгдсэн байна. 2015 онд хайгуулын 2235 тусгай зөвшөөрөл авах хүсэлт иржээ. Үүний 45 хувьд нь зөвшөөрөл олгосныг Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээлэв. Энэ нь нийт 13.9 сая га талбайг



С.Батсайхан / ЗГМ

хамарч буй аж. Ингэснээр энэ оны аравдугаар сарын байдлаар улсын хэмжээд ашиглалт болон хайгуулын нийт 3700 гаруй тусгай зөвшөөрөл байна. Үүний дийлэнх буюу 2140-ийг хайгуул, 1560-ыг ашиглалтын зориулалтаар олгожээ.

Энэ хэрээр хайгуулыг чиглэх мөнгөн урсгал ч эрчимжсэн. Өнгөрсөн онд тусгай зөвшөөрөл эзэмшигчид хайгуулын ажилд нийт 104 тэрбум төгрөг зарцуулсныг албаныхан мэдээлэв. Энэ нь 2013, 2014 оноос өссөн дүн. Хайгуулын “цонх” ийн нээгдсэнээр хувийн хэвшлийн оролцоо идэвхижсэн. Хөрөнгө оруулагчдын итгэл ч сэргэсэн гэдгийг салбарынхан хэлдэг. Гэвч энэ идэвхжил удсангүй. Жил гаруйн дараа тусгай зөвшөөрөл олголт түр зогслоо. Засгийн газраас дахин сэргээн гэж мэдэгдсэн ч өнөөг хүртэл олгож эхлээгүй л байна.

Төгрөгийн ханш үнэгүйдсэн. Ам.доллар Монголын эдийн засагт агаар, ус мэт хэрэгтэй байгаа нь маргашгүй үнэн. Гэвч доллар дуудах “хөзрөө” Засгийн газар өнөөг хүртэл ашигласангүй. Тэгвэл эдийн засгийг хямралаас

гаргахаа амалсан Засгийн газар эмхлэгдэн байгуулагдаад хэдэн сарыг үдэж байгаа билээ. Ам асууж, хариулт нэхэх л асуудал.

Өнгөрсөн есдүгээр сард болсон Монголд хөрөнгө оруулагчдын “Discover Mongolia” чуулганаар хайгуулын тусгай зөвшөөрлийг оролцогчид хөндсөн. Энэ үеэр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нээлттэй болгохоо амалсан юм. Мөн энэ үеэр хайгуулын тусгай зөвшөөрөл олголтоос үүдсэн зарим асуудлыг хэлэлцсэн. Тухайлбал, тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал, газрын тосны газар олгодог. Зөвшөөрөл авсан компани хайгуулын ажлаа эхлүүлэхтэй зэрэгцээд орон нутгийн засаг захиргаа, иргэдтэй зөрчил маргаан үүсдэг. Үүнээс үүдэн хайгуулын ажил удаашрах, компани алдагдал хүлээх эрсдэл тулгардаг. Цаашлаад гадаадын хөрөнгө оруулагчдад сөрөг “мессеж” болдгийг учирлав. Салбарын сайдын зүгээс энэ асуудлыг цэгцлэхээ мэдэгдсэн юм. Гэвч одоогоор ажил хэрэг болоогүй л байна. Энэ талаар албаны хүнээс тайлбар авахаар

оролдсон ч нэмэлт мэдээлэл өгсөнгүй.

Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээлсэнээр ирэх сараас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг зарлах юм. Ингэхдээ сонгон шалгаруулалтын журмаар

» 2015 оны эцэс гэхэд хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо хоёр дахин нэмэгдсэн байна.

» Өнгөрсөн онд тусгай зөвшөөрөл эзэмшигчид хайгуулын ажилд нийт 104 тэрбум төгрөг зарцуулжээ.

» Ирэх сараас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг зарлана.

явуулахаар төлөвлөжээ. Харин ирэх оны эхний улиралд өргөдлөөр олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг зарлана. Манай улс нийт нутаг дэвсгэрийн 19.8 хувь буюу 31 сая га талбайд тусгай зөвшөөрөл олгохоор төлөвлөдөг байгаа. Ийнхүү ирэх сараас тусгай зөвшөөрөл олголт сэргэх нь. Гэвч зөвшөөрөл авсны дараа гардаг үл ойлголцол, зөрчлийг одоогоор огт засаагүй байна.

Хайгуулын ажил эрчимжсэнээр богино хугацаанд хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, валютын урсгал нэмэгдүүлдгийг эдийн засагчид онцолдог. Үүгээр зогсохгүй уул уурхайн баталгаан нөөцийг өсгөдөг давуу талтай. Түүнчлэн ханшийн хямрал, хаяанд ирсэн өрийн дарамтыг хазаарлахад хайгуулын салбар онцгой чухал үүрэгтэй болох нь үүнээс харагдана. Хайгуулын салбар нь богино хугацаанд эдийн засгийг сэргээнэ. Хайгуулын ажил амжилт олж, ашиглалт эхэлсэн тохиолдолд дунд болоод урт хугацаанд Монгол Улсын эдийн засгийг үлэмж хэмжээгээр дэмжих боломжтой. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

29.9

Тэрбум ам.доллар. Монголыг чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт оны эхний гурван улиралд 29.9 тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин Монголоос гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалт 3.7 тэрбум ам.доллартай тэнцжээ.

» ҮЙЛЧИЛГЭЭ

176.7

Тэрбум төгрөг. Нийтийн хоолны салбарын орлого есдүгээр сард 176.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар өссөн дүн.

» ТҮҮХИЙ ЭД

6

Хувь. Алтны ханш арваннэгдүгээр сард нийт зургаан хувиар чангарсан байна. Ингэснээр шаргал металлын ханш унци нь 1180 ам.долларт хүрлээ.

» ҮНЭТ ЦААС

421

Тэрбум төгрөг. Монголбанк нэг долоо хоногтой 234 тэрбум төгрөгийн төв банкны үнэт цаасыг 15 хувийн хүүтэй арилжлаа. Ингэснээр нэг долоо хоногтой төв банкны үнэт цаасны үлдэгдэл 421 тэрбум төгрөгтэй тэнцэв.

» ДЭЛХИЙД

3.3

Хувь. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага дэлхийн эдийн засгийн ирэх оны төлөвийг 0.1 хувийн өсгөлөө. Ингэснээр манай гарагийн эдийн засаг 3.3 хувьд хүрэхээр байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ, доллар	2465.57
Евро	2614.49
Япон, иен	21.95
ОХУ, рубль	37.97
БНХАУ, юань	357.76
БНСУ, вон	2.11

УУЛ УУРХАЙ

Ашиг олж буй олборлогчдын тоо өсчээ

Б.Батманлай
Шинжээч

БНХАУ-ын сайн чанарын коксжих нүүрс олборлогч 112 уурхайн 94 хувь нь ес болон

аравдугаар сард ашигтай ажилласан тооцоог “В1”-ийн шинжээчид танилцууллаа. Өөрөөр хэлбэл, ашигтай ажиллаж буй уурхайн тоо наймдугаар сарын үзүүлэлтээс бараг хоёр дахин өсчээ. Металлургийн

нүүрсний үнэ он гарсаар гурав дахин өсөөд байгаа. Ялангуяа наймдугаар сараас хойш ханшийн өсөлт эрчимжсэн. Энэ нь компаниудын ашигт ажиллагаанд шууд дэмжлэг үзүүлжээ.

Мөн эрчим хүчний нүүрс

олборлогчдын дийлэнх нь ашигтай ажиллаж байгаа. Эрчим хүчний нүүрсний ханш аравдугаар сард 30 хувиар өссөн. Үүнээс үүдэн нийт эрчим хүчний нүүрсний уурхайнуудын 99 хувь ашигт ажиллагааны бүс

рүү шилжжээ. Гэхдээ дийлэнх компанийн ашгийн маржин тулт бага байгаа нь цаашид тогтвортой ашигтай ажиллана гэж таамаглахад эрсдэлтэй болохыг шинжээчид анхааруулж байгаа юм.

АМЕРИК
ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Bloomberg
TV MONGOLIA

"Америк хэрхэн ажилладаг вэ" цуврал-нэвтрүүлгээр Америк гэх их гүрний цөмд аваачиж, энэ орныг хөдөлгөдөг нүдэнд ил харагддаггүй ажиллагаануудын нууцыг нээдэг. Харин нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Америк орны эрчим хүчний аварга том машин-үлсынхаа хэрэглээг хэрхэн хангаж, амьдрах эх үүсвэрээр тэтгэж байдаг талаар хүргэх болно. Түүнчлэн эрчим хүч хаанаас үүсэлтэй, хэрхэн ашиглагддаг, үүнийг хэрхэн үргүй зарцуулдаг, айл өрх, албан байр бүрт хэрхэн нийлүүлдэг талаар хүлээн авч үзээрэй.

Пүрэв гараг /2016.12.01/

22:00

07:00/14:00 Баасан гараг /давталт/

11:00 Бямба гараг /давталт/

20:00 Ням гараг /давталт/

Эдийн засаг

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Зах зээлийн арилжаа зохиомол үнэ үүсгэхгүй

Судалгаанд оролцсон иргэдийн 62 хувь нь ам.долларын ханшийг оны төгсгөл хүртэл өснө хэмээн үзжээ

Төгрөгтэй харьцах ам.долларын ханш энэ сар гарснаар 25 хувиар өссөн. Энэ нь валютын ханшийн огцом хэлбэлзлийн нөлөө гэж зарим эдийн засагч үзэж байна. Шинэ жилийн уур амьсгал орж байгаа ирэх өдрүүдэд ам.долларын ханш цаашид хэрхэх нь анхаарал татсан хэвээр. Энэ асуудлыг хөндсөн “Валютын ханшийн огцом хэлбэлзэл, түүнийг тогтворжуулах арга замууд” сэдэвт хэлэлцүүлэг мягмар гарагт боллоо. Тус хэлэлцүүлгийг Хэвлэлийн хүрээлэнгийн дэргэдэх Эдийн засгийн сэтгүүлчдийн “Өөрчлөгч” клубээс зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Монголбанкны эдийн засагч Б.Түмэнцэнгэл, МҮХАУТ-ийн Ерөнхийлөгч Б.Лхагважав, Хөрөнгийн зах зээлийн зөвлөлийн судлаач А.Мөнхцог тэмдэглэлээ. Валютын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах сорилттой Засгийн газар болон Монголбанк тулгараад байгаа. Төгрөгтэй харьцах ам.долларын ханш зах зээл дээр өснө гэсэн хүлээлт өндөр байна. Энэ нь валютын ханшийн огцом хэлбэлзэлд ихээхэн нөлөөлж байгааг тус хэлэлцүүлэгт оролцсон “Монголын хөрөнгийн зах зээлийн зөвлөл”-ийн судлаач А.Мөнхцог хэллээ. Тэрбээр өөрсдийн хийсэн “Ам.долларын ханш цаашид яах



С.Батсайхан / ЗГМ©

вэ” нэртэй судалгааны дүнгээ сэтгүүлчдэд танилцуулсан юм.

Судалгаанд оролцсон иргэдийн 62 хувь нь ам.долларын ханшийг оны төгсгөл хүртэл өснө хэмээн үзжээ. Санамсаргүй түүврийн аргаар 300 хүнийг уг судалгаанд хамруулсан байна. Олон нийтийн 48 хувь нь ирэх оны хавар хүртэл ам.долларын ханш одоогийн түвшнээс өсөх хүлээлттэй байгааг судлаач А.Мөнхцог тэмдэглэлээ. Тэрбээр “Иргэдийн дунд ханшийн өсөлт үргэлжилнэ гэсэн хүлээлт давамгайлж байна. Тиймээс Монгол Улс мөнгөний захаа нээлттэй болгох хэрэгтэй. Зах зээлийн зарчмаар ам.доллараа арилжааж эхэлбэл зохиомол үнэ үүсэхгүй” гэв.

Ам.долларын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах зорилгоор Монголбанк

» Шинэ жилийн уур амьсгал орж байгаа ирэх өдрүүдэд ам.долларын ханш цаашид хэрхэх нь анхаарал татсан хэвээр.

» Төгрөгтэй харьцах ам.долларын ханш зах зээл дээр өснө гэсэн хүлээлт өндөр байна. Энэ нь валютын ханшийн огцом хэлбэлзэлд ихээхэн нөлөөлж байгааг судлаач А.Мөнхцог хэллээ.

» Монголбанкны валютын албан нөөц нэг тэрбум ам.доллартай тэнцэж байгааг тус банкны эдийн засагч Б.Түмэнцэнгэл тодотгов.

валютын дуудлага худалдаанд идэвхтэй оролцох болсон. Үүний нөлөөгөөр зах зээл дээрх валютын ханш тогтвортой түвшинд хадгалагдаж байна. Гэхдээ дунд хугацаанд ханшийн хүлээлт сөрөг байгааг уг судалгаанд дурджээ.

Монголбанкны валютын албан нөөц нэг тэрбум ам.доллартай тэнцэж байгааг тус банкны эдийн засагч Б.Түмэнцэнгэл тодотгов. Тэрбээр “Валютын нөөцөө нэмэгдүүлэх гарц, боломжийг төв банкны зүгээс эрэлхийлж байна. Тухайлбал, алт тушаалт нэмэгдэж байгаа нь нөөцөө тогтвортой түвшинд хадгалахад чухал үүрэгтэй” гэв. Монголбанкнд тушаасан алтны хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Өнгөрсөн онд 15.1 тонн алт худалдан авсан нь

2010 онтой харьцуулахад долоо дахин нэмэгдсэн. Тэгвэл энэ оны эцэст алтны тушаалт 16 тонн-ыг давах хүлээлттэй байна.

“Валютын ханшийн огцом хэлбэлзэл, түүнийг тогтворжуулах арга замууд” сэдэвт хэлэлцүүлэгт хувийн хэвшлийг төлөөлж буй МҮХАУТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав “Валютын ханшийн өсөлт, төгрөгийн бодлогын алдаа юм. Сүүлийн хүрээнийхэн болоод иргэд амсаж байна. Төгрөгийн үнэгүйдэл бол макро түвшинд гарч буй бодлогын алдаа юм. Гарч буй 3-4 жилд бизнес эрхлэгчид тун хүнд байдал ажиллаж байгаа. Компаниудын хувьд ажлын байраа хадгалахаар мэрижж байна. Энэ бол нөхцөл байдал хэрхэн хүндэрч байгаагийн илрэл. Тиймээс хөрөнгө


оруулалт татах, мега төслүүдэд эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлд Засгийн газар анхаарч ажиллах хэрэгтэй байна” хэмээн тэмдэглэлээ.

Манай улсын гадаад худалдааны тэнцэл сүүлийн хоёр сар дараалан ашигтай гарсан. Гэвч төгрөгийн ханшийн уналт үргэлжилсэн хэвээр байна. “Монголын хөрөнгийн зах зээлийн зөвлөл”-ийн судлаач А.Мөнхцог “Төлбөрийн тэнцэл өндөр алдагдалтай байгаа нөхцөлд гадаад худалдаа богино хугацаанд ашигтай гарах нь төгрөгийн ханшийн уналтад төдийлэн эерэг нөлөө үзүүлэхгүй. Харин урт хугацаанд гадаад худалдаа ашигтай байснаар нөлөө нь илүү гарна” гэж өгүүллээ.

Засгийн газраас эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн ханшийг чангалах зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг дуулгая. Ирэх онд хэрэгжүүлэх мөнгөний бодлогод валютын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах арга, хэрэгслийг шинээр нэвтрүүлэх болсныг Монголбанкны эдийн засагч Б.Түмэнцэнгэл онцоллоо. Тэрбээр “Ирэх онд баримтлах үндсэн чиглэлдээ валютын захын дэд бүтцийг хөгжүүлэх талаар зорилт тусгасан. Энэ хүрээнд нэгдсэн платформтой болохоор зорьж байгаа. Ингэснээр зах зээлд оролцогчид ямар ханшаар хэдий хэмжээний валютыг худалдах болон худалдан авах эрэлтийн мэдээллийг шуурхай харах боломжтой болно. Өөрөөр хэлбэл, мэдээлэл ил тод, хөрвөх чадвар өндөр валютын захыг бий болгох юм” хэмээн тэмдэглэлээ. [ЗГМ]

Монголбанк энэ сард найман удаа валютын дуудлага худалдаанд оролцож, хоёр удаа татгалзсан байна. Энэ хугацаанд нийт 224.1 сая ам.доллар зах зээлд нийлүүлжээ.

Хөрөнгийн биржийн индекс 0.28 хувиар өсчээ



MSE ALL

Монголын хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар нэг, хоёр болон гуравдугаар ангилалд бүртгэлтэй 15 хувьцаат компанийн нийт 18,855 ширхэг хувьцаа арилжжээ. Энэ өдөр долоон компанийн хувьцаа өсөж, таван компанийн хувьцаа буурсан бол гурван компанийнх тогтвортой байлаа. Үүнээс “Монгол алт” компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 13.89 хувиар

өссөн бол “Монгол Шуудан” 12.26 хувь, “Шарын гол”-ынх 5.04 хувиар тус тус өсчээ. Хөрөнгийн биржийн индекс мягмар гарагт 785.24 нэгж болж 0.28 хувиар өсөв. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.35 их наяд төгрөгт хүрчээ. Мөн Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 39 долоо хоногийн хугацаатай, 16,990 хувийн хүүтэй 80,785 ширхэг ЗГҮЦ арилжсан байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН
МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ
ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	60.39	▼ -1.08%	11/29/2016
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.019	▲ +5.26%	11/29/2016
PETRO MATAD	MATD	LON	GBX	6.175	▲ +12.5%	11/29/2016
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.033	▲ +3.13%	11/29/2016
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	11/29/2016
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.99	▲ +17.35%	11/29/2016
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.79	▼ -0.42%	11/29/2016
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.325	▼ -1.52%	11/29/2016
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.2	▼ -9.09%	11/29/2016
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.42	▼ -3.45%	11/29/2016

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1191.07	▲ +0.15%	11/29/2016
ЦАГААН АЛТ	PLA	унци	929.6	▲ +0.68%	11/29/2016
МӨНГӨ	SIA	унци	16.64	▼ -0.21%	11/29/2016
ЗЭС (COMEX)	HGA	фунт	263.4	▼ -1.37%	11/29/2016
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	72.15	▲ +0.47%	11/29/2016
WPTI TOS	CLA	баррель	46.65	▼ -0.91%	11/29/2016
БРЕНТ	COA	баррель	47.78	▼ -0.95%	11/29/2016
БЕНЗИН	XBA		140.25	▼ -0.72%	11/29/2016
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.324	▲ +0.12%	11/29/2016
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	319.95	▼ -0.16%	11/29/2016
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	92.25	▼ -0.27%	11/29/2016
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.199	▲ +0.5%	11/29/2016
БУДАА	RRA	центнер	9.59	▲ +0.05%	11/29/2016
БУУДАЙ	WA	бушель	414	▼ -0.6%	11/29/2016
КАКАО	CCA	тонн	2402	▼ -0.54%	11/29/2016
КОФЕ	KCA	фунт	1.566	▲ +0.8%	11/29/2016

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
I АНГИЛАЛД 3 КОМПАНИЙН НИЙТ 8,811 ШИРХЭГ ХУВЬЦАА 3,391,623 ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДСАН БАЙНА.				
АПУ ХК	APU	373.45	▲ 3.22 %	11/29/2016
ГОВЬ ХК	GOV	9960	▼ -4.23 %	11/29/2016
СҮҮ ХК	SUU	127.6	▼ -1.85 %	11/29/2016
II АНГИЛАЛД 9 КОМПАНИЙН НИЙТ 10,032 ШИРХЭГ ХУВЬЦАА 20,695,043 ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДСАН БАЙНА.				
АДУУН ЧУЛУУ ХК	ADL	1706	▼ -2.57 %	11/29/2016
БИ ДИ СЕК ХК	BDS	1400	◄ 0.00 %	11/29/2016
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	42000	▲ 5.00 %	11/29/2016
ЖЕНКО ТУР БЮРО ХК	JTB	60.95	▼ -0.08 %	11/29/2016
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	340	▲ 12.26 %	11/29/2016
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2500	▲ 5.04 %	11/29/2016
ЖУУЛЧИН ДЮТИ ОРИЙ ХК	SUL	35160	▲ 0.46 %	11/29/2016
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	2614	▲ 0.50 %	11/29/2016
МОНГОЛ САВХИ ХК	UYN	545	▼ -6.70 %	11/29/2016

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5368.813	-30.11	▼ -0.56%	11/29/2016
DAX INDEX	DAX	10552.74	-29.93	▼ -0.28%	11/29/2016
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15015.36	-60.08	▼ -0.4%	11/29/2016
S&P/ASX 200	AS51	5457.5	-6.9	▼ -0.13%	11/29/2016
S&P 500	INX	2201.72	-11.63	▼ -0.53%	11/29/2016
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3282.924	+5.92	▲ +0.18%	11/29/2016
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19097.9	-54.24	▼ -0.28%	11/29/2016
TOP 20	MSETOP	11002.54	+46.8	▲ +0.43%	11/29/2016
FTSE 100	UKX	6765.61	-33.86	▼ -0.5%	11/29/2016
HANG SENG	HSI	22737.07	-93.5	▼ -0.41%	11/29/2016
NIKKEI 225	NKY	18307.04	-49.85	▼ -0.27%	11/29/2016